



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-5</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>5-40</i>

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Газрын тосны боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцад хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	2-5
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /“Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	6-7
3.“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс угаах, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл сонсох	7-40

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 11 дүгээр сарын 13-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 68.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 20 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ц.Даваасүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Үүрийнтуяа.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Газрын тосны боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцад хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Баярмаа, Хяналт шалгалтын газрын референт Р.Дүүрэнбаяр нар байлцав.

Байнгын хорооны дарга С.Ганбаатар тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин санал хэлэв.

С.Ганбаатар: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 4

Бүгд: 16

75.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Х.Жангабыл, Ж.Золжаргал, Г.Лувсанжамц, П.Мөнхтулга, Г.Очирбат, Д.Үүрийнтуяа, Д.Энхтуяа, П.Ганзориг, Д.Батбаяр, Д.Энхтүвшин нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /“Тавантолгой түли” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Баярмаа, Хяналт шалгалтын газрын референт Р.Дүүрэнбаяр нар байлцав.

Байнгын хорооны дарга С.Ганбаатар тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, М.Бадамсүрэн, П.Мөнхтулга, М.Энхцэцэг, .Очирбат нар санал хэлэв.

С.Ганбаатар: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 3

Бүгд: 16

81.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 87.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа, гишүүдэд Улын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Г.Лувсанжамц, Д.Үүрийнтуяа, Б.Уянга, Д.Энхтүвшин, М.Бадамсүрэн, П.Мөнхтулга, М.Энхцэцэг, Г.Очирбат нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс угаах, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Намчинсүрэн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Түлш эрчим хүчний группын ахлах менежер С.Ашидмөнх, мөн группын менежер Н.Пүрэвдорж, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, мөн компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал Э.Түвшинжаргал, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга, Борлуулалт, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Цэрэндондог, Стратеги төлөвлөлт, төслийн газрын дарга Ц.Анх-Од, Салбарын нүүрс баяжуулах үйлдвэрийн газрын дарга Ө.Нямаа, Уул уурхай, технологийн газрын дарга Ч.Алтанбагана, “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Захиалагчийн хяналтын багийн менежер Г.Ган-Өлзий нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр, Хяналт шалгалтын газрын референт Р.Дүүрэнбаяр нар байлцав.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс угаах, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны тайланг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Стратеги төлөвлөлт, төслийн газрын дарга Ц.Анх-Од танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Г.Лувсанжамц, Х.Жангабыл, Д.Энхтүвшин, М.Бадамсүрэн, Л.Ганзориг, Г.Очирбат, Б.Пунсалмаа, Д.Батбаяр, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Намчинсүрэн, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, мөн компанийн Стратеги төлөвлөлт, төслийн газрын дарга Ц.Анх-Од, Салбарын нүүрс баяжуулах үйлдвэрийн газрын дарга Ө.Нямаа, Уул уурхай, технологийн газрын дарга Ч.Алтанбагана, Борлуулалт, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Цэрэндондог, “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Захиалагчийн хяналтын багийн менежер Г.Ган-Өлзий нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Д.Энхтуяа, Б.Уянга, Д.Энхтүвшин, М.Бадамсүрэн, Г.Очирбат, Ж.Золжаргал, С.Ганбаатар нар үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс угаах, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл сонсов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 10 минут үргэлжилж, 22 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 90.9 хувийн ирцтэйгээр 12 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЖ ҮЙЛДВЭРЖИЛГИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

С.ГАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их эзэн
Чингис хаан ” танхим 10 цаг 20 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

С.Ганбаатар: Эрхэм Их Хурлын гишүүдийн амар амгаланг айлтгая аа. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 11 сарын 13-ны өдрийн хуралдаан эхлэхэд бэлэн боллоо. Ирц бүрдсэн байна. Ингээд 10 цагт эхлэх ёстой хурал 20 минутын дараа эхэлж байна. Үндсэндээ бид аж үйлдвэрлэгчид ард иргэдээ хүндэтгэж өглөө эрт ирсэн гишүүддээ их баярлалаа. Ингээд бидний л ажил шүү дээ. Ирцийг танилцуулъя.

Бадамсүрэн гишүүн 6 дугаар тойрог, Далайн Батбаяр гишүүн 5 дугаар тойрог, Батлут гишүүн 4 дүгээр тойрог, Ганбаатар гишүүн 1 дүгээр тойрог, П.Ганзориг гишүүн, Х.Жангабыл гишүүн ирсэн байна 3 дугаар тойрог, Г.Лувсанжамц гишүүн ирсэн байна, П.Мөнхтулга гишүүн ирсэн байна 1 дүгээр тойрог, Б.Уянга гишүүн ирсэн байна, Д.Энхтуяа гишүүн ирсэн байна, Д.Энхтүвшин гишүүн ирсэн байна, М.Энхцэцэг гишүүн ирсэн байна, Пунсалмаа гишүүн ирсэн байна, Очирбат гишүүн ирсэн байна. Ингээд ирц хангалттай бүрдсэн учраас хуралдааныг эхлүүлъя.

Өнөөдрийн хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя.

Манай Байнгын хороо Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо Монгол орны хамгийн чухал асуудал бол аж үйлдвэрлэгч, ажлын байр. Энэнтэйгээ холбогдуулж төрийн өмчийн компани болон томоохон аж үйлдвэрлэгчдийн талаар ард иргэдэд мэдээлэл өгч болж байгаа зүйлүүдийг нь дэмжиж, болохгүй

байгаа зүйлүүд дээр нь засаж залруулах ийм ажиллагаа явуулна аа. Ингээд энэ асуудлынхаа хүрээнд Мөнхбаясгалан гишүүний санаачилж оруулж ирсэн асуудал байгаа.

Байнгын хорооны тогтоолын төслийг би та бүхэнд Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцад хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах гэсэн нэгдүгээр асуудал,

Хоёрдугаар асуудал, Энхтуяа гишүүнээс санаачилж орж ирсэн Байнгын хорооны тогтоолын төсөл

Тавантолгой түши компанийн үйлдвэрлэл технологийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах гэсэн 2 дугаар тогтоолын төслийг ажлын хэсэг байгуулна.

Гуравдугаар хэлэлцэх асуудал. Эрдэнэс Тавантолгой компанийн нүүрс угаах баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг өнөөдөр сонсож гишүүд асуулт асууж сонсох болно.

Ийм 3 хэлэлцэх асуудлыг орж ирж байна. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудлыг батлах уу? Ингээд хэлэлцэх асуудлыг баталлаа. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудлын нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцад хяналт шалгалт хийх үүрэг бүхий Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалангаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандан Монголын газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар тавьсан асуултын харууг Аж

үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн гишүүд энэ дээр анхаараарай. 114.1-д заасны дагуу 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэнтэй холбогдуулан тухайн асуудлыг шалган судлах холбогдох санал дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулах Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхнээр хэлэлцүүлэхээр тараасан байгаа.

Ингээд тогтоолын төслийг та бүхэндээ танилцуулъя.

Энэ дээр саяын ярьсан зүйл бол хэлэлцэж асуулга асуугаад Байнгын хороогоор хэлэлцээний дараа ажлын хэсэг бид ингээд байгуулж байгаа гэдгийг би танилцуулж байгаа юм. Ингээд тогтоолын төслийг танилцуулъя аа.

Ажлын хэсэг байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.2 дахь заалт Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Аж үйлдвэрлэлийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалангаас Монгол Улсын ерөнхий сайдад хандан Монголын газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар тавьсан асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 114.1-д заасны дагуу Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэнтэй холбогдуулан тухайн асуудлаар шалган судлах холбогдох санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгалтын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Л.Мөнхбаясгалан Улсын Их Хурлын гишүүн, гишүүд М.Бадамсүрэн,

Х.Жангабыл, Ж.Золжаргал, Г.Лувсанжамц, П.Мөнхтулга, Г.Очирбат, Д.Үүрийнтуяа, Д.Энхтуяа, П.Ганзориг, Д.Батбаяр гэсэн энэ бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг байна.

Ажлын хэсэг мэргэжил арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох салбарын мэргэжилтэн шинжээчдийг оролцуулж ажиллуулахыг ажлын хэсэгт Л.Мөнхбаясгаланд зөвшөөрсүгэй. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн Энхтүвшин гишүүн байна. Энхтүвшин гишүүнээр асуултыг тасаллаа. Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох хүсэлтэй байна. Тэгээд ажлын хэсгийн гишүүдэд нэрээ нэмж оруулж санал хураалгах хүсэлтэй байна. Баярлалаа.

С.Ганбаатар: Энхтүвшин гишүүний саналаар саналыг ажлын хэсэгт орууллаа.

Ингээд өөр асуулт байхгүй бол “Ажлын хэсэг байгуулах тухай” байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 75 хувийн саналаар ажлын хэсэг байгуулах тухай тогтоол батлагдлаа.

Ингээд та бүхэнд эрчимтэй хүчтэй ажиллахыг хүсэж байна. Энэ дээр үнэхээр Монголчуудын мөрөөдөл болсон газрын тосны асуудлаар Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо томоохон ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа. Эрчимтэй ажлын үр дүнгээ Байнгын хороондоо танилцуулна аа.

10.27 цагт

Ингээд хэлэлцэх асуудлынхаа хоёрт оръё.

*“Ажлын хэсэг байгуулах тухай”
Тавантолгой түли компанийн үйлдвэрлэл
технологийн үйл ажиллагаанд хяналт
шалгалт хийх үүрэг бүхий Байнгын
хорооны тогтоолын төслийг хэлэлцье.*

Улсын Их Хурлын гишүүн
Д.Энхтуяагаас гаргасан саналын дагуу
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын
хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы
хуралдааны дэгийн тухай хуулийн 110
дугаар зүйлд заасныг үндэслэн 2024 оны
10 дугаар сарын 30-ны өдрийн
хуралдаанаараа Тавантолгой түли
компанийн үйлдвэр технологийн үйл
ажиллагааны талаарх мэдээллийг
сонсож тухайн асуудлыг шалган судлах
холбогдох санал, дүгнэлт гаргах
шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг
бүхий хяналт шалгалтын ажлын хэсэг
байгуулах Байнгын хорооны тогтоолын
төслийг та бүхнээр хэрэгжүүлэхээр
тараасан байгаа.

Ингээд тогтоолын төслийг
унишиж танилцуулъя.

*“Ажлын хэсэг байгуулах тухай”
Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн
22 дугаар зүйлийн 22.3.3 дахь заалт
Монгол Улсын Их Хурлын хяналт
шалгалтын тухай хуулийн 9 дүгээр
зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Аж
үйлдвэрлэлийн бодлогын байнгын
хорооноос тогтоох нь:*

1. Монгол Улсын Их Хурлын Аж
үйлдвэрлэлийн бодлогын байнгын хорооны
хуралдаанаар Тавантолгой түли
компанийн үйлдвэрлэл, технологийн үйл
ажиллагааны талаарх мэдээллийг
сонссонтой холбогдуулан тухайн
асуудлаар шалган судлах, холбогдох санал,
дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл
боловсруулах үүрэг бүхий хяналт
шалгалтын ажлын хэсгийг дараах
бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Д.Энхтуяа
Улсын Их Хурлын гишүүн, гишүүд
Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа,

Г.Лувсанжамц, Д.Үүрийнтуяа, Б.Уянга
гэсэн Улсын Их Хурлын гишүүдээс
бүрдсэн байна.

2. Ажлын хэсгийн мэргэжил арга
зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох
салбарыг мэргэжилтэн шинжээчдийг
оролцуулж ажиллуулахыг ажлын хэсэгт
Д.Энхтуяад зөвшөөрсүгэй.

Аж үйл орчны бодлогын байнгын
хорооны дарга С.Ганбаатар гэсэн ийм
тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж
асуулт асуух гишүүд байна уу? Кнопоо
дарчхаарай.

Энхцэгэг гишүүнээр тасаллаа.
Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Тавантолгой түли
компанийн энэ ажлын хэсэгт нэрээ
оруулах хүсэлтэй байна. Тэгээд санал
хураалгаж жагсаалтад гишүүдэд нэр
оруулж санал хураалгаж өгөхийг хүсэж
байна. Баярлалаа.

С.Ганбаатар: Бадамсүрэн гишүүн
үг хэлье. Асуулт асууя.

М.Бадамсүрэн: Энхтүвшин
гишүүнтэй санал нэг байна.

С.Ганбаатар: Мөнхтулга гишүүн.

П.Мөнхтулга: Ажлын хэсэг маань
их цөөхөн хүнээр байгуулагдаж байна шүү
дээ. Тэгээд орж нэмэр тус болъё.

С.Ганбаатар: Мөнхтулга гишүүн
үг хэллээ. Энхцэгэг гишүүн.

М.Энхцэгэг: Би мөн адилхан
Энхтүвшин гишүүнтэй санал нэг байна.
Ажлын хэсэгт орж ажиллая.

С.Ганбаатар: Очирбат гишүүн үг
хэлье.

Г.Очирбат: Харин Тавантолгой түши компанийн нөгөө мэдээлэлтэй танилцаад ажлын хэсэгт нь орж ажиллах сонирхолтой байсан. Тэгээд ажлын хэсэгт нь орж ажиллая гэсэн саналтай байна.

С.Ганбаатар: Гишүүд асуулт асууж дууслаа. Энэ үнэхээр чухал асуудал. Тавантолгойн түши олон олон Монголчуудын амь амьдрал эрүүл мэнд бас цаана нь олон асуудлууд байгаа. Ингээд олон их наядын бас өр төлбөр ч явж байгаа. Энэ цаашид ер нь явах уу, үгүй юу гэдэг түгшүүртэй аюултай байдалд байгаа. Ингээд гишүүд анхаарал тавьж онцгой анхаарч байгаад талархалтай байна. Хамгийн гол нь үр дүн гаргаад эндээс гарсан тогтоолоо дахиад Байнгын хороогоор хэлэлцсэний дараа Засгийн газарт үүрэг чиглэл өгнө. Холбогдох газрууд нь хариуцлага тооцох эсвэл хууль тогтоомжид өөрчлөлт оруулах ийм боломжууд байгааг манай гишүүд ашиглана аа.

Ингээд Д.Энхтүвшин гишүүн, Бадамсүрэн гишүүн, П.Мөнхтулга гишүүн, Энхцэцэг гишүүн, Очирбат гишүүний нэрийг нэмж оруулаад тогтоолын төслийг баталъя гэсэн саналтай байна. Кнопоороо.

Далайн Батбаяр гишүүн дэмжсэнээр протоколд тэмдэглэе. Техникийн саатал гарсан. Ингээд 83 хувиар асуудал дэмжигдлээ.

10.32 цагт

Ингээд хэлэлцэх асуудлынхаа гуравт оръё. Дараагийнхаа хэлэлцэх асуудалд оръё.

Эрдэнэс Тавантолгой компанийн нүүрс угаах баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116.1-д

хуульд заасны дагуу эс үгүй бол Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд өөрийн санаачилгаар Засгийн газрын гишүүд Улсын Их Хуралд ажиллаад шууд хариуцан тайлагнадаг байгууллагын болон бусад байгууллагын мэдээллийг хурал дээр нь хэлэлцэж болно гэж заасан. Манай Байнгын хорооны ажлын албаныхан бас анхаараарай.

Өнгөрсөн удаа газрын тосныхон дээр орж ирэхэд би таслахад надад эвгүй байсан. Мөнхбаясгалан гишүүний асуулгад хариулахгүйгээр зүгээр л презентаци тавиад байдаг явдал бол гишүүд үйл ажиллагаанд бас нөлөөлж байгаа явдал шүү. Та нар маань анхаараарай, хажуугаас нь хэлнэ шүү.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

С.Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ТНБД, уг нь сайд нь тэндээ байгаа шүү дээ, наашаа дуудаарай. Энд Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хуралдаж байна шүү.

Асуудлаа танилцуулсны дараа асуулт дээр орж ирсэн байх ёстой шүү. Ашидмөнх Эрдэнэс Монгол компанийн Түши эрчим хүчний группийн ахлах менежер, босоод танилцуулаад. Н.Пүрэвдорж Эрдэнэс Монгол компанийн Түши эрчим хүчний группийн менежер, Мөнхжаргал Эрдэнэс Тавантолгой компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч, Мөнхжаргал танилцуулсан. Түвшинжаргал Эрдэнэс Тавантолгой компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал, Гантулга Эрдэнэс Тавантолгой компанийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга. Гантулга байна уу? Хамгийн чухал асуултад хариулах ёстой хүн ирээрэй. Дуудаарай. Цэрэндондог Эрдэнэс Тавантолгойн Борлуулалт, хөрөнгө оруулалтын газрын дарга. Гишүүдийн

асуултад хариулж байгаа, цаад утгадаа Монголын ард түмэнд та нар ажлаа тайлагнаж байгаа гэсэн үг шүү. Дуудаарай. Гантулга Цэрэндондог. Анх-Од Эрдэнэс Тавантолгой компанийн Стратеги, төслийн газрын дарга байна. Нямаа Эрдэнэс Тавантолгой компанийн салбарын Нүүрс баяжуулах үйлдвэрийн газрын дарга байна. Ган-Өлзий Барилгын хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын Захиалагчийн хяналтын багийн менежер байна. Ирсэн байна. Алтанбагана Эрдэнэс Тавантолгой компанийн Уул уурхай, технологийн газрын дарга Алтанбагана дарга ирсэн байна.

Ингээд гишүүддээ хандаж хэлэхэд Жавхланбаатар эд нар ороод ирэх байх. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам бол үндсэндээ үйл ажиллагаа, үйлдвэрлэл, бүтээмж, үр ашгийн талаар гол хариуцаж ажиллаж байгаа. Энэ дээр 2 байгууллага ирсэн байгаа 2 том гол хариуцаж байгаа. Эрдэнэс Монгол болон Эрдэнэс Тавантолгой компани бол 100 хувь өмчлөл, санхүүжилт, хөрөнгө оруулалт, ноогдол ашиг Монголын ард түмэнд ямар ноогдол ашигтай байна. Гэрээ хэлэлцээрүүдийн талаар бас гол хариуцаж байгаа. Өөр бусад асуудлуудыг нь би бүгдийг нь дурдсангүй. Ингээд та бүхэн тус компанийн нүүрс угаах баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг Эрдэнэс Тавантолгой компанийн Стратеги төлөвлөлт төслийн газрын дарга Анх-Од танилцуулна аа. Танилцуулгаа хийнэ үү.

Ажлын хэсгийн хэддүгээр микрофон дээр байна? 3 дугаар микрофон.

Ц.Анх-Од: Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн нүүрс угаан баяжуулах үйлдвэрийн талаар товч танилцуулгыг хийе.

Нүүрс баяжуулах үйлдвэрийн гол хэрэгцээ шаардлага зорилт нь болохоороо Тавантолгой ордын нүүрсийг нөөцийг хаягдал багатай, иж бүрэн ашиглаж, экспортын орлогыг нэмэгдүүлэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн эрдэс Монгол нэгдлийн аж үйлдвэрийн гинжин хэлхээний үндэс болж нүүрсийг гүн боловсруулах дараачийн гүн боловсруулалтын суурийг тавих тийм зорилго гол зорилготой байгаа. Энэ үйлдвэрийн тус төслийн маань дэмжсэн Их Хурлын хэд хэдэн тогтоол шийдвэр, Засгийн газрын тогтоолууд байдаг.

Хамгийн эхнээс нь дурдах юм бол 2018 оны Их Хурлын 73 дугаар тогтоол байгаа. Мөн 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2 мянга 2020-оос 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт зорилт болон туссан байгаа. Мөн 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан шинэ сэргэлтийн бодлогын аж үйлдвэрийн сэргэлтийн нэг зорилт болон батлагдсан байгаа. Мөн өөр тус төсөл маань өөрөө Засгийн газрын 2021 оны 113 гэсэн тусгайлсан тийм тогтоол шийдвэрийн дагуу хэрэгжсэн төсөл байгаа.

Төслийн хүчин чадал бол жилд 10 сая тонн түүхий нүүрс хүлээн авч баяжуулах хүчин чадалтай. Өнөөдрийн байдлаар төслийн гүйцэтгэл 95.5 хувьтай хэрэгжиж явж байна. Төслийн нийт 133 га талбайг хамарсан төсөл хэрэгжиж байна. Нийтдээ үндсэн болон туслах 67 барилга байгууламжаас бүрдсэн ийм цогцолбор төсөл байгаа. Үйлдвэр бол 10 саяын үйлдвэр маань 56.7 литр секунд ус ашиглан баяжуулах төлөвлөгөөтэй үйлдвэр байгаа. Усны эх үүсвэрийг Загийн усны хоолой гүний усны ордоос 63.6 литр секунд нөөцтэй. 25 жил ашиглагдах нөөцтэй. Үйлдвэрийн зориулалттай ийм усны нөөцөөр усаа хангаж байгаа. Эрчим хүчний хэрэглээний хувьд 110, 35, 10 квт-ын 2-ыг үржих нь 25 мвт-ын чадал бүхий дамжуулах дэд станцыг барьж байгуулан төслийн эрчим хүчний хэрэгцээг хангаж байна аа. ТЭЗҮ тооцооллоороо бол нийт

457 ажилтан шаардлагатайгаас өнөөдрийн байдлаар 198 ажиллах хүчнийг бүрдүүлэн ажиллаж байна. Эдгээрийн 30 хувийг орон нутгаас бүрдүүлсэн байгаа.

Төсөл 2021 оны 9 сард ТЭЗҮ фийд батлагдаж хүлээж авснаас хойш ерөнхийдөө эхлээд 2022 оны 7 сард барилга угсралтын ажлыг эхлүүлж байсан бол сая үйлдвэрийн туршилт тохируулгын ажил 2024 оны 10 сард дуусаад энэ 11 сардаа багтаан улсын комисс ажиллуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна аа. Яг жигдрээд байнгын ашиглалтад орох хугацаа бид нар 2025 оны 3 сараас эхлээд жигдэрсэн байдлаар ажиллана гэдэг хүлээлт төлөвлөгөөтэй ажиллаж байна аа.

Төслийн ерөнхий төлөвлөлтийн хувьд бол түүхий нүүрсний 150 мянган тонны 2 агуулах, агуулахаасаа хүлээн авсан нүүрсээ бутлаад үндсэн үйлдвэрээрээ оруулж баяжуулаад баяжуулсан бүтээгдэхүүн хаягдлаа бүгдийг нь усгүйжүүлэх цехээр дамжуулан усыг нь эргүүлэн ашиглаад тэгээд хаягдал завсрын бүтээгдэхүүн, баяжмалын тус бүрийн агуулахуудад агуулан цаашаа төмөр зам авто замын ачилтаар ачилт хийж экспортод гаргах ийм ерөнхий төлөвлөгөөтэй үйлдвэр байгаа. Үйлдвэрийн онцлог гэвэл байгаль орчинд ээлтэй, тоосгүйжүүлэх системтэй, агааржуулалтын системтэй. Энэ 5 ширхэг битүү агуулахуудыг төлөвлөж өгсөн байж байгаа. Мөн ашигласан усныхаа 96.6 хувийг буцаж үйлдвэртээ цэвэршүүлэн эргүүлэн ашиглана. 3.4 хувь одоо алдаж байгаа ус маань зөвхөн бүтээгдэхүүний чийглэг хэлбэрээр алдаж байгаа. Ил задгай ус алдахгүй, ийм усны хэмнэлттэй, өндөр хэмнэлттэй үйлдвэр байгаа.

Мөн дээрээс нь бүрэн автомат автомашин болон вагонд ачих системийг төслийн хүрээнд шийдэж өгсөн байж байгаа.

Дээрээс нь ажилчдын амьдрах нөхцөлийг бүрдүүлэх 300 ажилтны хотхон, оффис хооллох заал, спорт заалыг мөн цуг шийдсэн байгаа. Нүүрс баяжуулах үйлдвэрийн ерөөсөө гол давуу тал нь болохоороо Тавантолгойн ордод нийтдээ 13 нэр төрлийн тэгээд салаа давхаргуудыг тооцох юм бол 35 өөр төрлийн харилцан адилгүй ийм шинж чанартай нүүрс байдаг. Тэгээд энэ дотор бол чанар сайтай муутай зөндөө нүүрсүүд ингээд холилдож байгаа. Тэдний чанар тааруу нүүрсийг бол угааж баяжуулах замаар экспортын шаардлага хангуулах ийм гол үндсэн зорилготой ийм төсөл байгаа юм аа. Шат дамжлагын хувьд ярих юм бол уурхайгаас олборлосон нүүрсийг таналт буюу бутлалт ачилтын тусдаа дээр бутлаад үйлдвэр рүү хүргээд үйлдвэр маань 10 сая тонн нүүрс хүлээж авсан бол түүнийгээ баяжуулаад 5.6 сая тонн баяжуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлээд 2.2 сая тонн мийтлинг буюу эрчим хүчний нүүрс үйлдвэрлээд түүнийгээ авто болон төмөр замаар экспортлох ийм төлөвлөгөөтэй ерөнхийд нь шууд шат дамжлагатай байгаа. Үйлдвэрийн дотоод технологийн зохион байгуулалтын хувьд үйлдвэр рүү 50 мм буюу 5 сантитай нүүрсийг бутлаад үйлдвэр рүү оруулаад тэрийгээ цааш нь ахиж ширхгээр нь 3 ангилан хүнд орчны циклон ти би эс буюу нягтралт хянах машин гэдэг ийм тоноглолуудыг нийтдээ 500 орчим тоноглолыг ашиглан ийм баяжуулахаар дотоод технологийн зохион байгуулалттай үйлдвэр байгаа. Энэ слайд дээр болохоор үйлдвэрийн ТЭЗҮ фидийн үед төлөвлөж байсан зураг төсөл болон бодит гүйцэтгэлийн харьцуулсан зургуудыг харуулсан байна аа.

10 сард туршилт тохируулгын ажлыг 2024 энэ оны 7 сараас эхлүүлээд 10 сард сая дуусгасан байж байгаа. Туршилт тохируулгын хүрээнд нийтдээ 45500 мянган тонн нүүрс хүлээн авч баяжуулаад 20 мянган тонн баяжмал, 17.8 мянган тонн завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн ийм үр дүнтэй ажилласан. Туршилт тохируулгын хүрээнд хүлээж авсан

нүүрсний дундаж чанар гэвэл үнслэг 20 хувьтай, жи индекс 49 хувьтай, дэгдэмхий бодисын гарц 25.1 хувьтай байсан бол баяжуулсан бүтээгдэхүүний чанар нь үнслэг нь 10.4, жи индекс нь 80. Дэгдэмхий бодисын гарц 25.34 буюу зах зээлийн шаардлага хангасан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн байгаа. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс сая 2024 оны 10 сарын 25-ны өдөр 2 багц буюу 12.8 мянган тонн нүүрсийг биржээр арилжаалсан. Биржийн арилжаалсан үнэ нь тонн тутамд 163.5 доллар. Нийтдээ тус арилжаанаас 2.1 сая долларын ийм орлого олсон байж байгаа.

Тэгээд дараачийн биржийн арилжааг бид нар 12 сард зохион байгуулах төлөвлөгөөтэй байна. 12 сард 55 мянган тонн нүүрс ахиж баяжуулаад угаан баяжуулаад 30.2 мянган тонн баяжмал үйлдвэрлэхээр ийм төлөвлөгөөтэй ажиллаж байна.

2025 онд бол нийтдээ 5.6 сая тонн нүүрс хүлээж авч баяжуулна. Үүнээс баяжуулсан хатуу коксжих нүүрсний баяжмал 1.6 сая тонныг үйлдвэрлэнэ. Хагас зөөлөн коксжих нүүрсний баяжмал 1.3 сая тонныг үйлдвэрлэж эрчим хүч хүчний нүүрс буюу мидлинг нийтдээ 1.5 сая тонныг үйлдвэрлэх төлөвлөгөөтэй 25 оны төлөвлөгөөг гаргасан байгаа. Нийт хөрөнгө оруулалтын хувьд 1 их наяд 88 тэрбум буюу 320 орчим сая доллар байгаа. Үүнээс санхүүжилтийн гүйцэтгэл 84.2 хувьтай буюу 915.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байж байгаа. Эдийн засгийн үр ашгийн тооцооны хувьд анх ТЭЗҮ-ээр нэг жилийн орлогыг 754.8 сая доллар байна. Нийт зардал 644.9 татварын дараах ашиг 67.7 хувийн ашигтай гэдэг тийм ТЭЗҮ-ийн тооцоолол хийгдсэн байдаг. Тэгээд тус нүүрсний үнэ сүүлийн үед нэмэгдсэнтэй холбоотой тооцооллын шинэчлэн боловсруулж сая хийсэн байж байгаа.

Тэгээд тус тооцооллоор бол 10 сая тонн бүтэн бүрэн хүчин чадлаараа ажиллахад 1.1 тэрбум долларын

орлоготой, 620 сая долларын зардалтай, татварын дараах ашиг 366.6 сая доллар байхаар тооцоо гарсан. Тэгээд тус баяжуулах үйлдвэрт угааж баяжуулах нүүрс, баяжуулж борлуулах нүүрсийг яг түүхийгээр нь тэр чигээр нь борлуулбал ямар ашиг орлоготой ажиллах юм бэ гэдэг тооцоог мөн харьцуулах байдлаар хийсэн байж байгаа. Тус нүүрсийг шууд борлуулах юм бол 918 сая долларын орлого олж, 528 сая долларын ашигтай. Татварын дараах ашиг 292.8 сая доллар. Ашгийн түвшин 31.9 байхаар байгаа. Тэгэхээр баяжуулснаараа ашгийн түвшинийг компанийн хэмжээнд 1.1 хувиар өсөх нь ионн тутамд ярих юм бол ашиг нь 5.2 доллароор нэмэгдэх ийм эдийн засгийн үр ашгийн тооцоо гарсан байж байгаа.

Мөн дээрээс нь төслийн шууд бус үр ашгийн үзүүлэлтүүд байгаа. Үүнээс дурдах юм бол хаягдал чулуулгийг ялгаж үлдээснээр түүнийг тээвэрлэхэд шаардагдах 25 сая долларын зардлыг хэмнэх боломжтой.

Дээрээс нь цаашидаа дотоод овоолго үүсгээд явах юм бол олборлолтын зардлаас жилд 10 орчим сая долларын хэмнэлт хийх боломжтой. Мөн орон нутгаас 30-аас доошгүй хувийн ажиллах хүчнийг бүрдүүлж байгаа болохоороо тус хүмүүс маань бүсчилсэн хөгжлийг дэмжих ийм үр нөлөөтэй гэж үзэж байгаа. Мөн 457 мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх нь цаашидын аж үйлдвэрлэлийн хөгжил болон өрхийн эдийн засгийг дэмжих том нөлөөтэй гэж харж байгаа.

Мэдээж дотоодын ханган нийлүүлэлт нэмэгдэж дотоодын ААН-үүдийн бас үйл ажиллагааг дэмжих давуу талуудтай байгаа.

Дээрээс нь үйлдвэрээс гарсан хаягдлыг бас барилгын материал гэх мэтчилэн өөр зүйлсүүдэд ашиглаад дараачийн аж үйлдвэрийн гинжин хэлхээний суурь болгох боломжтой

байгаа. Компанийн зүгээс цаашидаа 4 томоохон төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Хөрс тээврийн конверын системийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Ус хангамжийн нэмэлт эх үүсвэрийн төслүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна. Мөн Тавантолгой ДЦС-ын төслийг гүйцэтгэгч шалгарсны дараа төслийг эрчимжүүлэн хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Дээрээс нь Цогтцэций сумд ажиллаж амьдарч байгаа компанийн ажиллах хүч нэмэгдэж байгаа тул тус сумын шинэ суурьшлын бүсийн хөгжилд бас хувь нэмрээ оруулах ийм төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа. Мэдээлэл өгч дууслаа.

С.Ганбаатар: Мэдээлэл хийсэн Анх-Од даргад баярлалаа.

Мэдээлэл хийлээ.

Ингээд мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Энэ чинь ирцээрээ шүү ирцээрээ орж ирж байгаа. Ингээд Уянга гишүүн асуулт асууна уу?

Б.Уянга: Өглөөний мэнд хүргэе. 3 асуулт байна. Байнгын ашиглалтад баяжуулах үйлдвэрийг 2025 оны 3 сард авахаар төлөвлөж байгааг харлаа. Тэгээд энэнээс өмнө нь ашиглалтад оруулах тийм боломж байна уу? Яг ямар ямар асуудлуудыг шийдвэрлэж байж 3 сард оруулахаар төлөвлөж байгаа вэ? Энэ дээр нь ямар нэгэн дэмжлэг бид нарын зүгээс байгаа эсэх дээр хариулаад өгөөрэй. Тэгээд ер нь бол өнгөрсөн 4 жилд хийгдсэн хамгийн том ажил бол нэлээн эрт баригдчих байсан нүүрс баяжуулах үйлдвэр маань ингээд биелэлээ бүрэн бүтцээ олоод биеллээ олоод ингээд

ашиглалтад орох гэж байгаа явдал гэж үзэж байгаа. Тэгээд таны сая танилцуулсан слайд дээр ч тэр нэмүү өртөг шингээгээд экспортлож чадсанаар Монгол Улс эргээд тэрийгээ дагаад илүү их тийм ашиг шимийг нь хүртэх бололцоо нь бүрдэж байгаа учраас энэ нүүрсний баяжуулах үйлдвэрээ бүрэн хүчин чадлаар нь аль болох түргэн л оруулчихвал бид нарт л илүү хэрэгтэй.

Усны асуудал. 2 дугаар асуулт нь бол усны асуудалтай холбоотой. Тэгээд яах вэ 56.7 литр усны хэрэглээг Загийн усны хоолойгоос татаад ингээд 96.6 хувийн дахин эргэлт эргэлдүүлээд тэгээд ямар ч гэсэн усныхаа усаа дахин ашигласан байдлаар өндөр хувьтайгаар ашиглах бололцоо бүрдсэн байна. Ер нь бол газрын доорх усны хайгуул дээр Эрдэнэс Тавантолгойгоос ажил хийгдсэн үү? Цаашид ер нь хайгуул хийх төлөвлөгөө байна уу? Одоо Цагаан цавын усны 220 литр секундийн ус татахаар энэ сүүлийн слайдад гарлаа шүү дээ.

Дараа хийх гэж байгаа 4 ажил гээд. Тэгээд тэрэн дээр яг ойроосоо тийм эх үүсвэр олж болохоор байна уу? Хайгуулдаа уг нь бас мөнгө зарцуулбал хэрэгтэй байх аа. Би урьд нь Алтанбагана инженертэй ярьж байсан санагдаад байна аа. Тэгээд нэг тодорхой яг үнийн дүнгээ хийж байсан гэсэн хариулт авсан. Тэгээд тэрэн дээр энэ жил өнгөрсөн жил нэлээн устай жил байсан учраас дахиад нэг анзаараад хайгаад үзвэл яадаг юм. Доошоо нэвчилт явагдсан байх болов уу гэсэн ийм бодолтой сууж байлаа.

Гурав дахь асуулт нь болохоороо Мөнхжаргал захирал ороод ирчихсэн байгаа учраас энийг заавал асуухгүй бол болдоггүй. Энэ болохоор Эрдэнэс Тавантолгойн төв оффис Улаанбаатар хотод байгаад байдаг. Тэгээд энэн дээр та хэд маань яг Өмнөговийн Цогтцэций рүү нүүх дээр ямар нэгэн арга хэмжээ авч байна уу? Засгаар тогтоолууд ч байна уу, тэмдэглэл ч байна уу гарч байсан байх ёстой. Тэгээд энэнийхээ хэрэгжилт дээр

ямар төлөвлөгөө байгаа вэ? Яагаад ингэж асууж байна гэхээрээ нөгөө Эрдэнэтэд Эрдэнэтийн удирдлагууд нь тэндээ байгаа учраас нэлээн сайн хот болоод хөгжөөд ингээд байгаа юм шиг санагддаг. Тэгээд мэдээж шалтгаан байгаа учраас Улаанбаатарт яг төв удирдлага нь байгаад байдаг байх аа. Гэхдээ яг тийшээгээ нүүгээд очих юм бол илүү үр дүнтэй байх болов уу засаглалын хувьд гэж бодогдох юм.

Тэгэхээр Мөнхжаргал захирал энэ дээр хариулаад өгөөрэй.

С.Ганбаатар: Асуултад маш тодорхой хариулъя. Тэр яагаад Эрдэнэттэй адилхан ингээд нүүхгүй байна вэ гээд. Энэ их олон жил ярьж байгаа шүү. Ингээд Уянга гишүүний асуултад хариулт өгье. уу 7 номерын микрофоныг өгье. Та нар гараа өргөөд өргөөд хариулаарай.

Х.Мөнхжаргал: Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Эрдэнэс Тавантолгой ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Мөнхжаргал байна аа. Уянга гишүүний асуусан асуултад хариулъя.

Гуравдугаар асуултаас нь эхлээд хариулъя. Манай компанийн хувьд бол Даланзадгад хотод байрлах ийм хуучнаар мэргэжлийн хяналтын байрыг бол ерөнхийдөө ашигла гээд Засгийн газрын тогтоол шийдвэр бол гарчихсан байгаа. Ер нь бол 2025 ондоо бол үе шаттайгаар компанийн төв оффисыг нүүлгэхээр компанийн хувьд төсөвтөө суулгаад төлөвлөөд ажиллаж байгаа юм. Энэ дээр гол асуудал нь болохоор түрүүн танилцуулга дээр гарч байна. Шинэ суурьшлын бүс Эрдэнэс Тавантолгой компани 100 хувь өөрийн санхүүжилтээр санхүүжүүлж байгуулахаар зураг төсөл бүх юмаа гаргаад аймгийн Засаг даргад өгчихсөн байгаа. Энэ дээр гол асуудал нь бол тухайн Улаанбаатар хотод ажиллаж амьдарч байгаа ажилтнуудын орон байр гэр бүлийн, нөгөө сургууль,

цэцэрлэг асуудлуудыг шийдэхгүйгээр маш их хэмжээний зардал гарахаар байгаа. Тэгэхээр бид нар үе шаттайгаар 2025 оноос эхлээд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа юм.

Ер нь бол хөрөнгө оруулалт шинэ суурьшлын бүсийн асуудал нь өөрөө бас хөрөнгө оруулалт ихтэй учраас аймгаас нийлээд хамтран ажлын хэсэг бид нар байгуулчихсан байгаа. Тэгээд энэ ажил бол хийгдээд явж байгаа. 2025 оноос эхлээд үе шаттайгаар оффис шилжээд явах байх аа.

Нэг, хоёрдугаар асуудлын хувьд манай төсөл хариуцсан дарга Анх-Од хариулах уу?

С.Ганбаатар: 3 дугаар микрофоныг нээж өгье. 4 минутад дотор багтааж их товчхон, тодорхой хариулаарай. Уянга гишүүний 1 дүгээр асуултад хариулъя.

Ч.Алтанбагана: Байнгын ашиглалтад авах 3 сард гэж тавьсан байгаа. Тэгэхдээ энийг наашаа татах боломж байгаа. Яг манай төсөл дээр хамгийн түрүүнд шийдвэрлэх нэг шаардлагатай нэг асуудал нь 11 сардаа багтаад улсын комисс ажиллуулах шаардлагатай байгаа. Тэгээд улсын комисс нь эрчим хүчний цахилгааны ажил болон дулааны станц дээр ЭХЯ-аас комисс ажиллана. Бүх барилга байгууламж дээр БХБЯ-аас ажиллана. Мөн уул уурхайгаа баяжуулах үйлдвэрийг хүлээж авах журмын дагуу Уул уурхайн яамнаас мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас мөн Улсын комисс ажиллах ёстой байгаа. Тус 3 комиссын ажлыг яаралтай зохион байгуулж комисст иж бүрэн хүлээж авсны дараа байнгын ашиглалтад орох боломжтой байгаа.

Хоёрдугаар асуулт буюу усны ашиглалт хайгуул дээр манай компани мөн уурхай ордоо тойроод 200 км радиустай хайгуул хийх тендерийн ажлыг

зарлаад шалгарчихсан байгаа. 2 номероос хариулна.

С.Ганбаатар: 6 номер нэмэлт мэдээлэл өгье.

С.Ганбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Хоёр дахь асуултыг хариулъя.

Тавантолгойн ордын хувьд гидрогеологийн судалгааны ажил бол хангалтгүй хийгдсэн байдаг. Энэ судалгааны ажлыг бид нар энэ жилээс нэлээн эрчимжүүлээд явж байгаа. Ингэхдээ уурхайн бүсийн 100 км орчимд үнэхээр энэ хэсэг дээр усны асуудлууд байгаа юм уу, ус байгаагүй гэвэл эцэслэн тогтоосны дараа бид нар их дүнтэй гадаргын усны төсөл гэх төслүүдийг хэрэглэх үү, эсвэл энэ гүний уснуудын их хэмжээгээр нөөц байна уу гэдгийг судлахаар төлөвлөөд ажиллаж байна. Энэ жилийн хувьд бол говийн бүсэд маш их хур тунадастай байсан. Уурхайн эргэн тойронд бид нар 2 хөвд цөөрөмтэй эргэн тойронд 4.5 сая м³ ус тогтсон. Ирэх жилийнхээ төлөвлөгөөнд бид нар энэхүү хөвд цөөрмөө сайжруулаад газрын гүн рүү алддаггүй дээш нь гадаргаар ууршдаггүй маягаар нь ахин төлөвлөгөө хийгээд ерөнхийдөө гадаргын усыг цаашидаа уул уурхайн үйлдвэрлэлдээ тогтмол ашиглахаар ийм юмнуудыг бизнес төлөвлөгөөндөө ингээд тусгаад явж байгаа.

С.Ганбаатар: Уянга гишүүн их л тодорхой асуултууд асууж байсан. Өөр нэмэлт хариулт байна уу? Уянга гишүүн хангалттай гэж үзэж байна уу?

Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Энэ өдрийн мэндийг хүргэе. Манай тойргийн Сийрэст багт байгуулагдсан одоо ашиглалтад орох Баяжуулах үйлдвэр мэдээж Монгол Улсын экспортод том нөлөө үзүүлэхүйц

ач холбогдолтой гэж бодож ойлгож дэмжиж байгаа. Гэхдээ нэг одоо хэцүү юм нь ус. Цогтцэций сум бол усгүй болж байгаа сум шүү дээ. Тэгээд Загийн усны төсөл сүүлийн мэдээгээр бол 67 хувьтай, 68 хувьтай явж байгаа гэсэн мэдээлэл байна. Энэ чинь гүний ус шүү дээ тиймээ. Загийн хоолойн ус чинь. Гуван насос тавьж татна гээд байгаа. Хэдэн километр татах юм? Одоо тэр Загийн усны бүтээн байгуулалт нь хэр явагдаж байгаа вэ? Тэгээд сая бол хайгуул хангалтгүй явагдаж байгаа юм байна шүү дээ. Усны хайгуул. Тавантолгойн зүүн баруун цанхаас болоод тэр Улаан нуур руу цутгадаг ус тасарчихсан байгаа тийм үү? Тэгэхээр та нар усыг яаж хамгаалж яаж үр ашигтай зарцуулах талаараа нэг сайн мэдээлэл өгөөдхөөч. Тэгэх үү? Загийн ус төсөл чинь хэр явагдаж байгаа юм? Тендер зарласан байсан. Тэгээд усыг яаж үр ашигтай хэрэглэх юм. Тэр уурхайн тоосжилттой саарал ус хэрэглэх юм байгаа биз дээ. Энэ талаар хариулт авъя.

С.Ганбаатар: 3 дугаар микрофон дээр хариулъя. Технологийн ямар шийдэл байгаа вэ? Хөрөнгө оруулалтын, тоног төхөөрөмжийн ямар шийдлээр усыг хэмнэх гэж байгаа вэ гэж их тодорхой асууж байна.

Ц.Анх-Од: Загийн усны хоолой төслийн талаар мэдээлэл өгье өө. Загийн усны хоолойн төсөл нүүрс баяжуулах үйлдвэрээс бол 90-ээд километрийн зайд нийтдээ оршиж байгаа. 18 худгаас усаа татаж аваад гол шугамыг нь дамжуулах гол шугам 70 км үргэлжилж байгаа. 2 өргөх насостой. Ийм бүтээн байгуулалтын бүтэцтэй ийм төсөл байгаа. Төсөл бол 100 хувь хэрэгжээд дууссан. 2024 оны 10 сар буюу сарын өмнө улсын комисс ажиллаад, одоо улсын комиссын дүгнэлт эцэслэх шатдаа явж байна аа. Яг зөвхөн Баяжуулах үйлдвэрийн хувьд ярих юм бол усыг ашиглах үүднээс ТЭЗҮ-ийн шатаас нь эхлээд маш их ач холбогдол өгч ажиллаж байсан. Яаж ач холбогдол өгсөн бэ гэхээр усаа эргүүлж шахаж авах тийм хамгийн

өндөр чанарын филтер пресс гэдэг төхөөрөмжүүдийг баяжмал, завсрын бүтээгдэхүүн, хаягдал болон гурвууланд нь ижил түвшинд төлөвлөж өгсөн байж байгаа. Ингэснээр усны эргүүлэн ашиглалтын түвшин 96.6 гэдэг өндөр түвшинд гарч байгаа юм аа.

Нэмэлтээр 6 номероос хариулъя.

С.Ганбаатар: 6 номер.

Ч.Алтанбагана: Би нэмэлтээр Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя.

Уул уурхайн хувьд яалт ч үгүй хамгийн том асуудлууд энэ говийн бүсэд ажиллаж байгаа манай шинэ суурьшлын бүс гээд бүгд дээр энэ усны асуудлууд байгаа. Энэ дээр түрүүн би хэлсэн. Нэмэлтээр бид нар хайгуулын ажлуудыг судалгааг бүр эцэслэж хийгээд усны нөөц говийн бүсэд байх ёстой хэр хэмжээнд байгааг бол эцэслэн тогтоох нь эхний шаардлага байгаа. Одоо бид нар байгаа нөөцөөрөө Улаан нуур дээр бол хөв цөөрөм маягийн далан үүсгэсэн гадаргын усаа бид нар тогтоогоод зам усалгаандаа ингээд ашиглаад явж байгаа. Цаашидаа уурхайг ингээд 150 сая уулын цулыг ингээд жилийн хугацаанд ингээд хөдөлгөөд явах юм бол Эрдэнэтээс 3, 4 дахин их хэмжээний хөдөлгөөн явах юм бол мэдээж тоосжилт ч асуудал хүнд үүснэ. Энэнтэй холбогдуулаад бид нар дэвшилтэт технологи гэх юм энэ конверын системийг нь хөрс тээвэр дээрээ, нүүрс тээвэр дээр ингээд хэрэгжүүлэхээр төслийг өнгөрсөн жил Эрдэс баялгийн зөвлөлөөр батлуулаад одоо анхных нь Монголдоо хамгийн урт 12.

С.Ганбаатар: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Усны төлбөр, ус ашигласны төлбөр танайх хэдийг өгөх вэ? Одоо нийгмийн хариуцлагын хүрээнд гэдэг юм уу Загийн уснаас гүний ус

ашиглаж байгаагийнхаа нийгмийн хариуцлагын хүрээнд юу хийх вэ?

С.Ганбаатар: Хариулъя. Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг нээе.

Ц.Анх-Од: Ус ашиглах гэрээнүүдийг сав газрын захиргаа болон холбогдох байгууллагуудтай байгуулсан байж байгаа. Тэгээд тарифын дагуу төлбөрөө төлөөд явна. Ойролцоогоор 5 мянга орчим тонн метр кубтэй, 5 мянган төгрөг метр кубтэй төгрөгийн хураамжийг зөвхөн ашиглалтын хураамж хэлбэрээр төлж байгаа.

Дээрээс нь нэмээд зардал гарна. Нийгмийн хариуцлагын хүрээнд бол цаашидаа үе шаттай орон нутгийн ажилчдыг сургаж, ажлын байраар хангах ажлын нийт ажиллах хүчний 30-аас доошгүй хувийг заавал орон нутгаас хангах ийм бодлогыг нэн тэргүүнд барьж ажиллана гэдэг төлөвлөгөөтэй байгаа.

С.Ганбаатар: Дараагийн ээлжид бичгээр ус хэдэн тонн ус гарч байгаа юм. Хэдэн хувь нь ууришиж алдаж байгаа юм, хэдэн хувь нь үйлдвэрлэлд ашиглаж байгаа юм. Ашиглалтын алдагдал дээр хэдийг ашиглаж байгаа юм. Энэ тоо баримтуудаа мэдээллүүдээ их тодорхой бичгээр Мөнхбаясгалан гишүүнд өгөөрэй та бүхэн. Дэлгэрүүлж өгөөрэй.

Ингээд Лувсанжамц гишүүн асуулт асууя.

Г.Лувсанжамц: Өглөөний мэнд хүргэе. 2 асуулт байна.

Эхнийх нь болохоор энэ үйлдвэрээс дайвар бүтээгдэхүүн гарах уу дайвар бүтээгдэхүүнээ ашиглаад ямар нэгэн бүтээгдэхүүн боловсруулж борлуулах ч байдаг юм уу зах зээлд нийлүүлэх байдаг юм уу тийм төлөвлөгөө байгаа юу тэндээс ямар нэгэн ашиг олно гэж тооцож байгаа юу гэсэн эхний асуулт байна.

Жишээ нь нүүрснээс боловсруулаад гараад үнснээс нь гипсэн хавтан үйлдвэрлэх боломж байдаг. Тавантолгой цахилгаан станц хэрвээ баригдана гээд явж байгаа бол тэрэнтэйгээ уялдсан байдлаар гипсэн хавтангаа дотооддоо үйлдвэрлээд нийлүүлдэг болчих юм бол давхар ашиг эдийн засагт үүсэх болов уу гэж бодож байна.

Хоёрдугаарх нь нийгмийн хариуцлагын хүрээнд хийж байгаа шинэ суурьшлын бүсээр бүсийн талаар асуумаар байна. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө гэж батлагдсан байгаа гэж бодож байна. Энэнтэй хэрхэн уялдуулж байгаа вэ? Сумын ерөнхий архитектур байгаа болов уу? Одоогийн байдлаар бол 600 айлын орон сууц, 960 хүүхдийн сургууль, 240 хүүхдийн цэцэрлэг, 400 хүний оффис гэж байна. Ер нь бол байгууллагынхаа өөрсдөө тэнд ажиллах ажилчдадаа зориулж барьж байгаа юм байна гэж ойлгож байна. Одоогийн байдлаар Цогтцэций сумд 2 ЕБС-тай. 1080 суудалтай гэхдээ ачаалал нь давчихсан буюу 2800 сурагч сурч байгаа юм байна. Сургуулийн байр нь хүрэлцээгүй, 4 цэцэрлэг байдгаас 800 ортой цэцэрлэг нь мянган хүүхэд сурч байгаа гэсэн хүмүүжиж байгаа гэсэн тийм тооцоонууд байна л даа. Энэ талаар нийгмийн хариуцлагын хүрээнд аймгийн болон сумын ерөнхий төлөвлөгөө болон та бүхний хэрэгжүүлэх гэж байгаа энэ шинэ суурьшлын бүс нь хэрхэн уялдах вэ. Хэрвээ та бүхний энэ шинэ суурьшлын бүсийн төлөвлөгөө гарсан бол бичгээр танилцах хүсэлтэй байна гэсэн ийм 2 асуулт байна.

С.Ганбаатар: 2 номерын микрофоныг нээж өгье. Сайн байцаана уу?

Ө.Нямаа: Нүүрс баяжуулах үйлдвэрийн газрын дарга Нямаа байна. Эхний асуултад нь хариулъя. Үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхтэй холбоотой ямар нэгэн арга хэмжээ авч байсан уу гээд. Нүүрс

баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг хийхдээ гарсан хаягдлыг бол дахин боловсруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр бол тусгаж өгсөн байдаг. Эндээс бол 2 төрлийн бүтээгдэхүүн хаягдал гарч байгаа. Хаягдлыг бол яг ширхгээс нь хамааруулаад бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой нөхцөлийг нь бүрдүүлж ялгаж үйлдвэрлэлээс анхнаас нь ялгаж авахаар төлөвлөөд энэнийхээ дагуу бол 2 төрлийн хаягдал болгон ялгаж авсан. Тэрнийхээ тоо 1 мм-ээс доош ширхэгтэй хаягдал нь өөрөө тодорхой хэмжээнд дулаан ялгаруулдаг. Ийм шаварлаг материал байдаг. Энэ дээр бол эхний байдлаар барилгын материал үйлдвэрлэх хавтан үйлдвэрлэхтэй холбоотой судалгааг бол хийхээр бол ажиллаж байна. Энэ нь бол Үйлдвэр технологийн паркийн цаашидын нөгөө жижиг дунд үйлдвэрлэлтэй холбоотойгоор өргөжүүлж судалгаа хийхээр төлөөлөн ажиллаж байгаа.

С.Ганбаатар: 3 номерын микрофоныг нээж өгье.

Ц.Анх-Од: Гишүүний 2 дугаар асуултад хариулъя. Төслийн газрын дарга Анх-Од байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд Цогтцэций сумын шинэ суурьшлын төлөвлөгөөг Эрдэнэс Тавантолгой компани санхүүжүүлээд хийж гүйцэтгээд батлуулаад, сум орон нутаг болон аймагт хүлээлгэж өгсөн байж байгаа. Тус төлөвлөгөөгөөр бол 3 үе шаттай хүн амыг тооцоод эхний ээлжид 10 мянган хүн амтай төвлөрлийн бүс болно дунд шатад 20 мянга болно. Эцсийн шатад 50 мянга хүртэл хүн ам нь өсөх ийм төлөвлөгөөтэйгөөр шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулсан байгаа. Үүнийхээ хүрээнд манай төлөвлөсөн байгаа 600 айлын орон сууц 250 хүүхдийн цэцэрлэг 900 хүүхдийн сургууль зэрэг нь яг шинэ суурьшлын бүсийн төлөвлөгөөтэйгөө уялдаж газруудаа төлөвлөсөн байж байгаа. Сумаасаа бол газраа төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар хуулийн дагуу газраа аваад эзэмчихсэн байж байгаа.

Одоо зураг төсөл хийгдэхээр хүлээгдэж байна. Суманд ямар дэмжлэг үзүүлсэн бэ гэхээр сургуулийн.

С.Ганбаатар: Ерөнхий план байгаа юу? Ерөнхий аудиторын хариуцаж байгаа хүн энэ тухай асууж байсан даа. Асуултад болсон байх.

Жангабыл гишүүн асуулт асууя.

Х.Жангабыл: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Эрдэнэс Тавантолгой ХК-д баяр хүргэе. Ажлын амжилт хүсье. Янзын гоё үйлдвэр барьчихсан байна шүү дээ. Нүүрс баяжуулах үйлдвэр. Тэгээд бас 02 давхаргаас чанар муутай нүүрсийг 20 хувийг нь хэрэглэдэг юм байна. Чанар сайтай 3, 4 давхаргаас 30 хувийг нь хэрэглэдэг юм байна үйлдвэрт. Үлдсэн 50 хувийг нь аль давхаргаас хэрэглэх юм бэ? Үйлдвэрт. Нэг дэх асуулт.

Хоёр дахь асуулт Мөнхбаясгалан гишүүн байнга усны талаар ярьдаг асуудалтай говийн бүсэд. Энд нэг хувийн компани Админерал гээд. Бас нүүрс баяжуулах үйлдвэр барьж байгаа юм. Миний авсан мэдээллээр бол хуурай аргаар ус хэрэглэхгүй ингээд нүүрс баяжуулдаг гээд сонссон. Тэгэхээр танай үйлдвэр энэ технологиор ус хэрэглэхгүй хуурай аргаар нүүрсээ баяжуулж болдоггүй юм уу? Энэ тал дээр бас хариулт авмаар байна.

Гуравдугаарт түүхий нүүрсний чанарын асуудал маш их яригддаг. Чанар дээр баяжуулсан энэ нүүрс дээр ер нь чанарын асуудал яригдах уу. Та нар яг норм хэмжээндээ үйлдвэрлэж чадаж байна уу гэсэн асуултууд байна. Тэгээд энэ завсрын буюу эрчим хүчний нүүрс байна. Энийг хаана борлуулах гэж байна? Хятад улс авдаг уу? Бас энэ Тавантолгой дулааны станц төсөл хэрэгжүүлэх гэж байгаа юм байна. Энэ үйлдвэр дээр технологийн хувьд таарах уу гэсэн асуултууд байна аа. Баярлалаа.

С.Ганбаатар: Техникийн чанартай чухал асуулт асуулаа. Хэн хариулах вэ? Технологи бүтээмжийн талаар.

Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг нээж өгье.

Ө.Нямаа: Нүүрс баяжуулах үйлдвэрийн газрын дарга Нямаа байна нүүрсний давхаргын хольцтой холбоотой ер нь нүүрс баяжуулах үйлдвэрийн гол зорилго бол шууд баяжуулах зарах боломжгүй давхаргууд буюу 0 давхаргыг 40 хувиар өндөр үндэслэгтэй буюу 18-аас 24 хувийн үндэслэгтэй 3 4 дүгээр давхаргуудыг бол 30 орчим хувиар мөн дэгдэмхий бодис нөгөө өндөртэй 30 орчноос дээш стандарт хангадаггүй үнэ нь бага байдаг нүүрсүүдийг бол 20-оос 30 хувийн агуулгатай авахаар ерөнхийдөө тооцоо судалгаа хийгээд эхний байдлаар бүтээгдэхүүн үйлдвэрлээд явсан байж байгаа. Цаашидаа бол энэ хэмжээгээ ерөнхийдөө бариад явна аа.

Хуурай баяжуулах үйлдвэрийн тал дээр бол Нүүрс баяжуулах үйлдвэр нь ер нь 2 хуурай болон нойтон гэсэн үндсэн 2 технологитой байдаг. Хуурай баяжуулах үйлдвэр нь бол нарийн ширхэгтэй нүүрсийг бол баяжуулж авч чаддаггүй байж байгаа. Жишээлбэл Адмирал гээд компани дээр байгаа технологи бол 6-аас доош миллиметрэй нүүрсийг бол баяжуулах боломжгүй. Энийг бол хуурай аргаар бол баяжуулдаггүй учраас нойтон аргаар баяжуулах ёстой болно. Тэгээд энийг салгаж авч үлдээгээд дараа нь нойтон баяжуулах үйлдвэр барьж байж баяжуулдаг байж байгаа.

Хоёрдугаарт 6-аас дээш миллиметрийн ширхэгтэй хуурай том ширхгийг бол үнсийг бол нойтон баяжуулах үйлдвэртэй адилхан хянах бүрэн боломжгүй. Ерөнхийдөө ерөнхийдөө ашиг төрлийн коэффициент нь бол нэг 70 орчим хувьтай байдаг. Яах вэ нойтон нүүрс баяжуулах үйлдвэр 90-ээс 95 хувьтай байдаг. Дэлхий нийтийн

жишигээр бол нойтон баяжуулах үйлдвэр барьж байгаа гол шалтгаан нь бол хаягдалгүй бүрэн ашиглах гэдэг шалтгаантай. Гол тулгамдаж байгаа асуудал бол мэдээж усны асуудал байж байгаа. Түүнээс яг технологийн хувьд бол хүлээн зөвшөөрөгдсөн явж байгаа нь бол нүүрс баяжуулах нойтон байж байгаа. Дараагийнх нь эрчим хүчний нүүрсний хэрэглээтэй холбоотой асуудал. Баяжуулах үйлдвэр нь дунджаар нэг 2 сая орчим эрчим хүчний нүүрс үйлдвэрлэнэ. Энэчээнээс бол эхний ээлжид бол Тавантолгой түли компанид бол бид нар жилд дунджаар 600-аас 800 мянган тонн эрчим хүчний нүүрсийг бол нийлүүлэхээр ажиллаж байна. Цаашид үлдэгдэл нүүрс нь бол Тавантолгой ДЦС-д бол нийлүүлэхээр төсөлд нь тусгасан байдаг. Төсөл маань цаашидаа хэрэгжээд явчих юм бол 900-аас 1 сая 200 мянган тонн эрчим хүчний нүүрс бол авахаар ажиллаж байгаа. Тэгээд ер нь бол дотоод хэрэгцээгээ бол хангах бүрэн боломжтой байгаа. Тэгээд нүүрсний чанарын асуудал дээр сая эрт ярьсан. Эрчим хүчний нүүрсний ч сая баяжуулсан үйлдвэрээс бас эхний бүтээгдэхүүн маань бол Монгол Улсад эрт Тавантолгой түли компанийг үйлдвэрлэж байгаа стандартыг бол бүрэн хангасан байж байгаа.

Дээрээс нь бол баяжуулсан нүүрсний стандартыг бол бүрэн хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байж байгаа. Тэгэхээр энэ дээр бол цаашидаа асуудал гарахгүй байх аа.

С.Ганбаатар: Жангабыл гишүүн тодруулж асууя.

Х.Жангабыл: Энэ эрчим хүчний нүүрсийг ахуйн хэрэглээнд хэрэглэж болохоор ойлгогдчихлоо зөв үү? Тэгвэл энэ Тавантолгой түли компанийг ер нь алдагдалтай юм бол хаачихвал яасан юм? Танайх угаасаа үйлдвэрлэх юм байна шүү дээ. Дараа жилээсээ энэ жил ч яах вэ өнгөрсөн байх.

С.Ганбаатар: Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг нээж өгье.

Ц.Анх-Од: Тавантолгой түли ХК-ийн хэрэглэж шахмал түли үйлдвэрлэж байгаа нүүрс бол Энержи ресурс компанийн мөн адил завсрын бүтээгдэхүүнийг ашиглаж үйлдвэрлэж байгаа. Тэгэхээр манай баяжуулах үйлдвэрээс гарах завсрын бүтээгдэхүүн тэрэнтэй чанарын ер нь яг ялгаагүй. Эрчим хүчний ахуйн хэрэглээнд хэрэглэж болохоор ийм нүүрс нүүрс байгаа.

Дээрээс нь өмнө нөгөө баяжмал үйлдвэрлэсэнээр чанарын маргаан гарах уу гэж. Одоо бол яг түүхий нүүрс борлуулж байгаа учраас чанар бага зэрэг хэлбэлзэхэд маш их маргаан гарч асуудал ингээд дагуулдаг. Баяжуулах үйлдвэр өөрөө чанараа тогтмол бариад байж байгаа. Түүхий нүүрс буюу орц талдаа ингээд чанар хэлбэлзэхэд тэрийгээ гарцын хэмжээнээсээ ингээд гарц нь өөрчлөгдөөд ингээд тохируулдаг учир бүтээгдэхүүний чанар маш тогтмол гардаг. Тэгэхээр баяжмал борлуулахад бол ямарваа нэгэн чанарын маргаантай асуудал бол үүсэхгүй ээ.

С.Ганбаатар: Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Тавантолгой компанийн хамт олонд баяр хүргэе. Тэгээд энэ төсөл маш их чухал ач холбогдолтой төсөл байгаа. Нөөцийн ашиглалтыг жигд ашиглах энэ бололцоо боломжуудыг бий болгож өмнө нь бол ингээд сорчилж ашиглаж байсан бол гарц сайтай 3, 4 дүгээр давхаргаа экспортолж байсан бол бодоо энийгээ 30 хувь хүртлээ бууруулж бусад давхаргуудаа 04-ийн Си гэдэг давхаргуудаа ашиглахаар болж байгаа нь нөөцийн ашиглалт талаасаа энэ ард түмний баялгийг үр ашигтай ашиглах дээр маш их зөв төсөл амжилттай хэрэгжүүлж баяр хүргэе ээ. Тэгээд энэтэй холбоотой нэг 2, 3 асуулт байна.

Нэгдүгээрт нь нүүрс угаахад ер нь борлуулалтын зах зээл хэв маяг өөр болдог. Өмнө нь бол та бүхэн одоо жишээлбэл худалдааны компаниудаар дамжиж байгаа өөрөөр хэлбэл Хятадын угаах үйлдвэрүүдэд угааж байж цаашаа явдаг байсан бол угааснаараа та бүхэн шууд эцсийн хэрэглэгч дээрээ хүрэх бололцоотой. Яагаад гэвэл гангийн үйлдвэрүүд, кокс химийн үйлдвэрүүд хэзээ ч угаах үйлдвэр өөрсдөө бараг хийдэггүй. Тэгэхээр энэ борлуулалтын бүтэц ч энэ бүтээгдэхүүн чинь өөр болж байгаатай холбоотойгоор энэ борлуулалт дээрээ та хэд ямар нэгэн өөрчлөлт эцсийн хэрэглэгчтэйгээ шууд хамтарч ажиллах энэ бололцоо боломжийн талаар ямар ажил хийж байгаа вэ? Яагаад вэ гэхээр хэрвээ та хэд түүхий нүүрс зардаг шигээ ингээд худалдааны компаниудтай ингээд зууралдаад байвал та хэд зах зээлийнхээ өсөлтөө авч чадахгүй. Тэгэхээр энэ бололцоо боломжуудаа яаж хийх гэж байгаа вэ гэж нэгдүгээр асуулт байна.

Хоёрдугаарт нь эрчим хүчний нүүрс. Энэ угаах үйлдвэрийн ер нь бол хамгийн гол асуудал нь энэ хуримтлагдаж байгаа эрчим хүчний нүүрс болно. Тэгэхээр энэ овоологдоод ирэхээр тэр хавийн байгаль орчны асуудал болно. Энэ борлуулалтын асуудлуудыг ярихгүй бол зөвхөн дотоодын энэ хэрэглээ бол хаанаа ч хүрэхгүй. Тэгэхээр энэ том үйлдвэрлэл явж байх үед бол эрчим хүчний нүүрсний асуудал яригдана. Тэгэхээр яалт ч үгүй экспорттой холбоотой асуудлуудыг ярихгүй бол тэгээд ялангуяа энэ төмөр зам ороод ирэхээр тэр тээвэрлэлтийн зардал өртөг багасаад тэгээд энэ өрсөлдөх чадварууд тодорхой хэмжээнд нэмэгдэнэ ээ. Тэгэхээр энэ чиглэлээр хийгдэж байгаа ямар ажлууд байгаа вэ?

Дараагийн нэг асуудал нь болохоор нүүрсний ингээд олон бүтээгдэхүүнтэй болчхож байна. Угаасан коксжих нүүрс, завсрын бүтээгдэхүүн, эрчим хүчний нүүрс гэх мэтчилэнгээр ийм олон бүтээгдэхүүнтэй болж байхад ер нь бас хулгай хийх магадлалууд боломжууд

нэмэгдэнэ ээ. Жишээлбэл завсрын бүтээгдэхүүн гэж хэлээд угаасан нүүрс ачиж магадгүй. Тэгэхээр энэ бүтээгдэхүүн одоо энэ хяналт дээр та хэд төлөвлөж байгаа зүйл байгаа юу? Ийм 3 асуулт байна.

С.Ганбаатар: 5 номерын микрофон дээр хариулъя.

Г.Намчинсүрэн: Байнгын хорооны дарга, гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Аж үйлдвэрийн Эрдэс баялгийн яам Намчинсүрэн.

Эрдэнэс Тавантолгой болон нөгөө төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд бол уул уурхайн бүтээгдэхүүний биржээр бол бүтээгдэхүүнээ арилжаалах бол заавал арилжаалах зохицуулалттай байгаа. Тэгэхээр зэрэг бол Эрдэнэс Тавантолгой.

С.Ганбаатар: 5 номерын микрофоныг нээж өгье. Техникийн саатал гарч байх шиг байна.

Г.Намчинсүрэн: Тэгэхээр Эрдэнэс Тавантолгой бол энэ биржийн хуулийн хэрэгжилтийг бол хангаад дуудлага худалдааны зарчмаар бол цаашид бол борлуулалтаа хийгээд явах тийм зохицуулалттай байгаа. Зүгээр юун дээр бол биржийн арилжаан дээр бол Монгол Улсын нөгөө Засгийн газрын 2011 оны 193 дугаар тогтоолд заасан ангиллыг бол баримтлан ажиллаж байгаа. Тэгэхээр тэр тухайн ангилалд заасан нүүрсийг ямар хэмжээгээр борлуулах вэ гэдэг захиалгаа худалдан авагч нь тэр ангилалдаа нийцсэн бүтээгдэхүүнийг бол худалдан авах борлуулах тэрэн дээр нь бол Гаалийн ерөнхий газар энэ тэр бол хяналтаа тавиад ажиллаж байгаа.

С.Ганбаатар: 6 дугаар микрофон дээр нэмж хариулъя.

Ч.Алтанбагана: Эрдэнэс Тавантолгой Алтанбагана. Сая ингээд нүүрсийг олон төрөлтэй болоод ирэхээр

ингээд хулгай зэлгий гаргах асуудал үүсэх үү гээд. Өмнө бол компанийн хувьд нүүрсний агуулгууд давхардаг маягаар олгогдож явдаг байсан. Арван мянгад нэг овоолго. Одоо бол нэг овоолгын дугаар нэг удаа үүснэ. Тэр овоолгыг паспортжуулаад бирж дээрээ тавиад тэр компани худалдаж аваад зөвхөн тэр компанид ачигдаад тэр овоолго ингээд дуусна. Ахиж тэр овоолго 5 жил, 10 жилийн дараа гэж хүнд ачигдахгүйгээр ингээд энэ баримтуудыг нь овоолго үүсэхээс нэг баримт үүсгээд явж байгаа.

Дээрээс нь дотоодын цэргийн харуул хамгаалалттай, дээрээс нь чанар хяналтын гэдэг юмаар ярьж байна. Бирж дээр бид нар дуудлага худалдаагаа зарж байгаа болохоор овоолгынхоо дугаарыг тавиад зарж байгаа болохоор ямар нэгэн байдлаар худалдан авагчийн зүгээс бүх хүмүүс нээлттэй чанараа үзээд тэгж явж байгаа болохоор энэ тал дээр асуудал гарахгүй ээ.

Эрчим хүчний нүүрсэн дээр манай компанийн хувьд бол 2022 оноос нэлээн эрчимтэй энэ жилийн хувьд 2 сая шахуу эрчим хүчний нүүрс зарж байна.

С.Ганбаатар: Нэмэлт нэг минут өгье. 6 дугаар микрофон.

Ч.Алтанабагана: Ордны нэг нийт нөөцийн 40 хувь нь эрчим хүчний нүүрс байдаг. Тэгэхээр бид нар цаашидаа олборлолт нь маш их хэмжээний эрчим хүчний нүүрс олборлосны энийг бид нар борлуулах чиглэл дээр маш эрчимтэй ингээд биржээр дуудаад арилчхаж байгаа. Угаасан нүүрсүүдийн хувьд бол нөгөө сая эцсийн худалдан авагч нар бид нар БНХАУ-ын гангийн Baowu steel гээд том том компаниудтай уулзсан. Үйлдвэрүүд бол танай баяжуулсан нүүрсний чинь 4 үндсэн чанараас гадна бид нарийн петрнит болон нарийн хөөлт гэдэг дээжийн шинжилгээнүүд авах шаардлагатай байна аа. Эд нарын үндсэн дээр бид нар танай бүтээгдэхүүнийг коксын үйлдвэр болон гангийн үйлдвэр

авах боломжтой гэдэг дээр хамтран ажиллаад явж байгаа.

С.Ганбаатар: Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Тийм. Зарж байгаа бүтээгдэхүүн маань өөр болчхож байгаа учраас зүгээр биржээр юмаа зарна гээд ийм нэг идэвхгүй байдлаар хаяж болохгүй ээ. Тэгэхээр яг цаанаа тэнд чинь одоо жишээлбэл зорьж ирэх хүмүүсийг урьж саяын хэлдэг жишээлбэл эцсийн хэрэглэгчдийг гэрээ хийгээд тэд нарын жишээлбэл худалдан авагчийн агентуудыг нь жишээлбэл тэд нартайгаа хамтарч ажиллаад, тэд нар нь дуудлага худалдаанд ордог иймэрхүү юмнуудыг нэмж өгөхгүй бол яг л өмнөх нөгөө худалдааны компаниуд чинь л аваад л тэгээд л тэр зах зээлийн өсөлтийг чинь тэр эцсийн хэрэглэгчид хүрэх юмыг чинь тэр орон зайг чинь болохоор худалдааны компаниуд маань илүү ингээд аваад явчихдаг. Тэгэхээр бүтээгдэхүүн өөр болсон юм чинь та хэд илүү бас санаачилгатай байгаад зөвхөн биржийн худалдаанд цаанаас хэн орж ирэх нь биш хэн оруулж ирэх гэдэг юмнууд дээрээ сайн ажиллавал энэ нөгөө Монголын уур уурхайн бүтээгдэхүүн үнэ цэнд хүрэх ийм бололцоо боломжууд нээгдэнэ. Ер нь энэ саплай чинь бүтнээр нь эцсийн хэрэглэгчээсээ уурхай хүртлээ ингэж явахгүй бол жишээлбэл хайгуулаас авхуулаад ингэж явахгүй бол зөвхөн хилийн цаана бүх юмыг ингээд орхиж болохгүй ээ. Тэгэхээр энэ дээр та бүхнийг.

С.Ганбаатар: Энхтүвшин гишүүн үг хэллээ. Та нар анхаарч ажилдаа тусгаж ажиллах нь байна шүү. Их олон жилийн дараа нүүрснийхээ шинжилгээ судалгааг хийнэ гэдэг чинь юу гэсэн үг вэ? Энэ дээр бол цаг их алдаж байна аа. Ингээд Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

М.Бадамсүрэн: 2 асуулт, 2 санал байна.

Нэгдүгээрт үйлдвэрийн байршилыг сонгохдоо ер нь юун дээр үндэслэсэн бэ? Яг ордоосоо бол нэлээд хэмжээний зайтай байгаа, нэг.

Хоёрдугаарх нь хөрсийг конвеороор шилжүүлнэ гэж байгаа, зөөнө өө гэж байгаа юм. Тэгвэл нүүрс тээврээ конвеороор шийдэх үү? Одоо бол автомашинаар зөөж байгаа гэж ойлгож байгаа. Энэ бол их үр ашиг багатай. Тэгээд энэ 2-ыг асууя.

Хоёрдугаарт нь санал. Ер нь ямар ч төрлийн үйлдвэр, Нүүрс боловсруулах үйлдвэр, газрын тосны үйлдвэр, эрчим хүчний үйлдвэр 2 нь гол хэдэн зүйл дээр л тулгуурлаж байгаа шүү дээ.

Нэгдүгээрт бол түүхий эдийн нөөц.

Хоёрт нь усны нөөц.

Гуравдугаарт нь бол хэрэглэгч.

Тэгээд боомтдоо буюу зах зээлдээ ойр. Эсвэл төмөр зам дэд бүтэцтэй ойр. Тэгээд ажиллах хүчний нөөцийн хувьд гэсэн нэг ийм хэдэн зүйл дээр тулгуурлаж л үйлдвэрийн байршилыг сонгож байгаа юм л даа. Тэгээд яах вэ манай хувьд бол хүндрэлтэй асуудал байгаа. Элстэй говь газар динозаврын яс яагаад бүтэн олддог вэ гэхээр хуурай учраас бүтэн олдож байгаа шүү дээ. Тэгээд энэ говьд байгаа нүүрс чинь өөрөө ийм ус багатай геологийн тогтцын хувьд бол ийм учраас тийм коксжсон үнэ цэнтэй байна. Далайн эргийн орнуудад бол бас жоохон хүндрэлтэй. Тэгээд бидэнд нүүрс нь байна ингээд ус нь их хомсдолтой. Тэгэхээр одоо дэлхий нийтийн чиг хандлага бол энэ гүний усыг үйлдвэрлэлд ашиглахыг бол ер нь хориглож байгаа шүү дээ. Яагаад гэвэл энэ хүн амын тоо дэлхийд нэмэгдэж байна. Хуурайшил, дэлхийн дулаарал. Тийм учраас энэний ийм алтан дунджийг олж түрүүн Мөнхбаясгалан гишүүн асуусан, Жангабыл гишүүн асуусан. Ер нь энэ гүний усыг ашиглахгүй байх чиглэл рүү

л ер нь явна бид нар. Яах вэ өнөөдөр Монгол 3 сая гаруй хүн ам харьцангуй цөөтэй, өргөн уудам нутагтай тулдаа усны нөөцийн асуудал одоо хүн болгон нэг их ярихгүй байх шиг байгаа юм. Илүү одоо өнөөдрийн нөгөө орлого олох гээд ашиг олох гээд ажлын байр гаргах гээд ингээд яваад байгаа. Гэхдээ ирээдүйд энэ гүний ус гэдэг чинь боломжит нөөц гэдэг чинь асар олон 100 сая жилийн туршид бүрэлдэн бий болдог. Тэгээд өөрийгөө тэтгэх энэ чанараар асар бага байдаг.

Тийм учраас энэ усны хувьд бол та бүхэн онцгой анхаарч анхаарах хэрэгтэй. Өөр технологи орлуулах хэрэгтэй гэдэг саналыг би дэвшүүлж байгаа юм.

Хоёрт нь нийгмийн үнэлгээ гэдэг зүйлийг заавал хийх ёстой. Өөрөөр хэлбэл ростероор ингээд 14, 14 хоногоор уурхайчин залууд яваад байдаг байдлыг цаашидаа халах ёстой. Өөрөөр хэлбэл та бүхэн энд Эрдэнэт шиг, Багануур шиг төмөр замтай сургууль, цэцэрлэгтэй ийм нийгмийн асуудлыг нь хангаж гэр бүл нь ажлын байртай, хүүхэд нь гэрээсээ сургууль, цэцэрлэгтээ явдаг нөхцөлийг л бүрдүүлэх чинь хамгийн чухал асуудал болно. Тэгэхгүй эндээс онгоцоор очоод ингээд гэр бүл нь тусдаа байгаад.

С.Ганбаатар: Та дараа нь тодруулах юм байна. 3 номер хариулт өгье.

О.Цэрэндондог: Бадамсүрэн гишүүний 1 дүгээр асуултад хариулъя аа байршилтай холбоотой асуудал дээр. Яг одоо олборлолт явж байгаа Цанхийн уурхайгаас үйлдвэр нэг 15 орчим километрийн зайтай байрлаж байгаа. Гэхдээ энэ дээр хэд хэдэн шалтгаан байгаа л даа. Тавантолгойн орд маань өөрөө 64 мянган га талбайг хамаарсан 5 тусдаа ордоос бүрдсэн аягүй тийм маш том орд байгаа. Тэгэхээр нөгөө ирээдүйн олборлолтод өртөх нөөц тэр байршилуудаа бодож талбайг сонгосон байгаа. 2019 онд бол яг энэ зөвхөн байршилын асуудал дээр ЭХЯ, Уул уурхай

яам, ЗТЯ-ны хамтарсан ажлын хэсэг гараад хэд хэдэн хувилбарыг ярилцаад тэгээд саналаа Засгийн газарт танилцуулж ер нь байрлалыг эцэслэсэн байж байгаа. Тэгээд одоогийн сонгосон байрлал нь яг Зүүнбаян-Тавантолгой 2 чиглэлийн төмөр замын голд байрлаж байгаа. Мөн дээрээс нь Цанхи, Онч хараат, Бор толгой гэсэн 3 ордын голд байрлаж байгаа ийм байрлалтай байгаа.

Дээрээс нь үйлдвэр технологийн парк хэлбэрээр ирээдүйд цаашидаа хөгжих боломжтойгоор сул чөлөөтэй талбай хамгийн их боломжтой газрыг нь үндэслэж байрлалыг сонгосон байж байгаа.

6 номероос нэм нэмэлтээр хариулна.

С.Ганбаатар: 6 номерын микрофоныг нээж өгье.

Ч.Алтанбагана: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Бид нар Монгол Улсын Эрдэс баялгийн зөвлөлөөр нүүрс тээвэр болон хөрс тээврийн конверын ТЭЗҮ-ийг 2024 онд батлуулаад үүнийхээ дагуу 12.3 км нүүрс тээврийн конверынх нь тендер нээлттэй тендер сонгон шалгаруулалтыг зарлаад амжилттай гэрээ байгуулагдаад гүйцэтгэл нь 20 хувьтай явж байна. Энэ дууссаны дараа бид нар хөрс тээврийнхээ конверынхаа тендер сонгон шалгаруулалтыг үргэлжлүүлэн зарлаад явах юм аа.

С.Ганбаатар: Бадамсүрэн гишүүн тодруулъя гэсэн үү? Хариулахдаа нэрээ хэлээд яваад байгаарай. Протоколд бичигдэж байгаа шүү. Бадамсүрэн гишүүн нэмэлт асуулт асууя.

М.Бадамсүрэн: Үйлдвэр байгуулах нь хамгийн чухал байгаа ойлгож байгаа. Гэхдээ би нэг л зүйлийг хэлээд байгаа 2 юман дээр анхаараач гээд. Гүний усыг ашигладаггүй байх технологийг нэвтрүүлэх талаар олон улсын судалгаа

хийж эрдэмтэн мэргэдийг ажиллуулж явах ёстой. Энэ бол ирээдүйд хамгийн чухал зүйл болно. Түүхий эдийн орд нь байна, хэрэглэгч нь яг хажууд нь байна.

Ганцхан усны асуудал хүндэрнэ. Ингээд л усны нөөц дахиад нэмж тогтооно гээд л ийм тайлбар хэлээд байгаад бол би энэнд их сэтгэл дундуур байгаа. Ер нь говь чинь өөрөө усны асар их нөөц багатай газар шүү дээ. Тэгэхээр энийг одоо та нар та бүхэн гол бас анхаараарай.

Хоёрт нь тэр нийгмийн үнэлгээг маш сайн хийх ёстой. Өөрөөр хэлбэл бид нар байгаль орчны үнэлгээ хийдэг, ТЭЗҮ, техник эдийн засгийн үнэлгээ гээд нийгмийн үнэлгээ гэдэг зүйлийг сүүлийн жилүүдэд асар их орхигдуулсан. Тийм учраас та бүхэн маань уурхайчин залуус энэ танай компани 400, 500 ажлын байр гарах юм байна. Энэ залуучууд гэрээсээ ажилдаа явдаг. Хүүхдүүд нь.

С.Ганбаатар: Бадамсүрэн гишүүний үг хэллээ. Тэгээд саяын энэ саналыг ажилдаа тусгаж ажиллана. Шаардлагатай мэдээллүүдийг нэмэлтээр өгөх нь байна шүү.

П.Ганзориг гишүүн асуулт асууна.

П.Ганзориг: Аж үйлдвэрийн салбарт бас ийм томоохон төсөл үйлдвэрлэл бий болж байгаадаа бол талархаж байна. Энэ бол Монгол Улсын хөгжилд их чухал ач холбогдолтой ийм төсөл өө гэж харж байгаа. Тэгээд энэ коксжуулах үйлдвэрээс гарч байгаа тэр дайвар бүтээгдэхүүнүүдийг үр ашигтай ашиглах нь энэ төслийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой. Түүрүүн гишүүд дурдаж байна. Тэгэхээр нэгт яг үйлдвэр 3 сард бүрэн ашиглалтад ороод ажиллаад эхлэхэд шууд дайвар бүтээгдэхүүнүүд нь дагаад үйлдвэрлэлд ашиглагдаад явах боломжтой байгаа юу эсвэл хүлээгдэх үү? Одоо барилгын материалын тодорхой хавтан хийх боломжтой гэж байна. Тэр хаягдлуудыг

нь бид нар эрчим хүчний нүүрстэй холиод цахилгаан станцын бас төлөвлөж байгаа гэж байна. Энэ шууд ингээд ашиглаад явах уу гэдгийг тодруулмаар байна, нэгт.

Хоёрт энийгээ ашиглагдахаа яг энэ танай компани өөрсдөө шууд ингээд энийгээ зохион байгуулаад явахаар байна уу эсвэл Эрдэнэт дээр нэг овоолго үүсээд овоолгыг нь хувийн компаниуд ороод янз бүрийн нөхцөл байдалтай л яваад байгаа шүү дээ. Тэр үр ашиг нь улсын төсөвт бодитой орж ирдэггүй. Тэрэн дээр тодорхой ашиг сонирхлууд явдаг. Ингээд явах юм бол ийм нөхцөл байдал үүсэхгүй гэсэн баталгаа нь хэр байгаа вэ? Энэ дээр ямар тооцоо төлөвлөгөөтэй байна гэдгийг тодруулмаар байна.

Хоёрт энэ төсөл анх эхлэхдээ 314 орчим сая долларын өртөгтэй Норенкотой нөгөө оффтейк гэрээгээр хийсэн санхүүжилттэй төсөл. Тэгэхээр энэ одоогийн байдлаар санхүүжилт нь ямар хэмжээгээр олгогдчихоод байгаа вэ? Оффтейк гэрээ 100 хувь олгогдсон уу эсвэл тодорхой төлбөрүүдээ санхүүжилтийг нь яг өөрсдөө төсвөөсөө хийж байгаа юу? Нэгт.

Хоёрт яг оффтейк гэрээгээр олгосон бол нүүрснийхээ үнийг өгөхдөө ямар үнэ ханшаар тооцож өгч явж байгаа вэ гэдэг ийм 2 зүйлийг тодруулмаар байна.

С.Ганбаатар: Ганзориг гишүүний асуултад хэн хариулах вэ? 3 номерын микрофон.

О.Цэрэндондог: Дайвар бүтээгдэхүүн ер нь 2 төрлийн дайвар бүтээгдэхүүн гарч байгаа. Түрүүн дурдсан завсрын бүтээгдэхүүн буюу эрчим хүчний нүүрс. Одоогоор туршилтын хүрээнд завсрын бүтээгдэхүүн 18 мянга орчим тонн гарчихсан байгаа. Энэ бол шууд ашиглалт хэрэглэгдэхэд бэлэн байгаа. Одоо ирэх оны 2 сараас эхлээд Тавантолгой түши компани татан авалт хийгээд явах

төлөвлөгөөгөө гаргачихсан, гэрээ хэлэлцээрээ байгуулсан ажиллаж байна. Хаягдал бол дотроо 2 төрөл гарч байгаа. Том ширхэгтэй хаягдал, нунтаг ширхэгтэй хаягдал гэж 2 төрлийн хаягдал гарч байгаа. Одоогоор нэг 7 орчим мянган тонн хаягдал гарсан байж байна. Хувийн аж ахуйн нэгжүүд бол хаягдлыг ашиглах сонирхлоо ерөнхийдөө илэрхийлж эхэлж байна. Тэрэнтэй яг нарийвчилсан яриа хэлэлцээр хийх ажлууд хараахан эхлээгүй байна, эхлээгүй явж байна. Цаашидаа мөн Эрдэнэс Тавантолгой компани бол өөрсдөө яг тийм барилгын материал ч гэдэг юм уу тийм салбар руу орох юугүй байгаа. Үйлдвэр технологийн паркийн хүрээнд төр хувийн хэвшлийн санал санаачилгыг дэмжиж ажиллахад бэлэн байгаа.

Санхүүжилтийн хувьд бол оффтейк гэрээгээр нүүрс нийлүүлэх нөхцөлтэй тендер зарлаад шалгараад Норинко компани бол гэрээгээ хийгээд явсан байж байгаа. Тэгээд онцгой дэглэм тогтоосны дараа Норинко компанитай бол хэлцэл хийсэн. Хэлцэл хийгээд нэлээн удаан хугацааны хэлцэл хийж гэрээндээ шинэчлэлт оруулаад нийт нийлүүлэх нүүрсийг 20 хувиар багасгасан байж байгаа. 30 хувийг нь бэлэн мөнгөөр болгож нүүрсээр өгөх ёстой байсан. 90 хувийг 70 хувь хүртэл бууруулж гэрээгээ шинэчилж ингэж юу яасан байгаа?

Санхүүжилтийн гүйцэтгэлийн хувь нь өнөөдрийн байдлаар 84.2 хувьтай байж байгаа. Үүнээс бэлэн мөнгөөр олгосон санхүүжилт 418.8 тэрбум, нүүрсээр олгосон санхүүжилт 496.7 тэрбум байгаа. Нийтдээ 915.5 тэрбумын санхүүжилт олгосон байж байгаа. Санхүүжилтийн гүйцэтгэл 84 хувь байгаа ч төслийн гүйцэтгэл 95.5 хувьтай байгаа.

С.Ганбаатар: Зарим асуултад их дутуу хариуллаа. Ганзориг гишүүн тодруулж асууя.

П.Ганзориг: Тэр дайвар бүтээгдэхүүнүүдээ бол шууд ашиглаад

явах бол чухал ач холбогдолтой хугацаа алдаж болохгүй. Тэгэхээр энийгээ бас эртнээс энэ төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд ч байна уу даа хэрэгжүүлэхээр байна уу? Нээлттэй ил тод зарлаад явах хэрэгтэй. Тэгэхгүй бол ингээд овоолгууд үүсээд тэгээд хувийн хэвшил орж ирээд саналууд тавиад явж байгаа гээд энэ нь ил тод биш явж байгаа. Нэг бол ашиглагдахгүй ингээд овоолгууд үүсдэг эсвэл нэг хувийн сонирхлоор хүмүүс ороод нөгөө мэдээлэлдээ ойрхон эрх мэдэлтэй хүмүүс нь ашиглаад явдаг ийм байдал үүснэ ээ. Энийгээ бол тийм байдлаар ил тод, нээлттэй, эрт тодорхой болгоод явуулаасай гэж хүсэж байна, нэгт.

Хоёрт тэр оффтейк гэрээгээр төлбөр төлсөн нүүрснийхээ нэг тонны үнийг тодорхой хэлээдхээч ээ. Ямар үнээр өгсөн юм бэ? Зах зээлийн үнэ яг ямар байсан юм. Тэгээд оффтейк гэрээгээрээ хэдээр тооцож өгсөн юм бэ гэдгийг хэлчихмээр байна.

С.Ганбаатар: Саяын асуултад хариулъя 3 номерын микрофоныг өгье.

О.Цэрэндондог: Эрдэнэс Тавантолгой компанийн борлуулалт марктенгийн газрын дарга Цэрэндондог эрхэм гишүүний асуултад хариулъя аа.

Өнөөдрийн байдлаар энэ оффтейк гэрээний үнийг тухайн үед 2022 онд тогтоосон суурь үнээсээ олон улсын Хятадын зах зээл дээрх индексүүдээр тохируулга хийж үнийг тогтоодог байгаа. 2024 оны 4 дүгээр улирлын үнэ нь 74.55 ам.доллар байна аа.

С.Ганбаатар: Очирбат гишүүн асуулт асууя.

Г.Очирбат: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Тэгээд юуны түрүүнд манай Эрдэнэс Тавантолгой ХК-ийн удирдлагууд үнэхээр залуужсан байна. Сайхан харагдаж байна. Шижигнэсэн залуучууд энэ улсын төсөвт энэ аж

үйлдвэрийн салбарт ялангуяа Монгол Улсын том эдийн засагт нөлөө үзүүлж байгаа та хэддээ талархал илэрхийлье ээ.

Нэгдүгээрх асуулт бол бид нар ингээд яг энэ Тавантолгойтой холбоотой олон асуудлууд ярьдаг. Тэгээд хамгийн гол мөнгөний асуудал түрүүн басасуугдаад л байна. Би юу гэж асуух гээд байгаа юм гэхээр яг энэ жил яг өнөөдрийн байдлаар биржээр нийт заасан нүүрсний чинь хэдэн хувь зарагдсан бэ? Шууд гэрээгээр хэдэн хувь зарагдсан бэ? Оффтейк дээр хэдэн хувь байгаа вэ гэдгийг авчихъя. Би биржийн мэдээлэлтэй байгаа шүү. Та хэд тэгээд мэдээлэлтэй би тулгана гэж бодоод байгаа юм.

Хоёрдугаарт гэх юм бол энэ нэг тэнд ажилладаг нөгөө гаднынхан манай Монголчууд гээд ингээд олон тэнд ажил амьдралаа авч явдаг компаниуд, ААН-үүд, иргэд байна. Тэгээд тэр нэг юм яриад байх юм. Тэр нэг талд нь Монголчууд ажлаа хийхээр хямдхан үнээр хийгээд байдаг нөгөө талд нь гадаадууд хийхээр үнэтэй үнээр ажил хийгээд байдаг гэдэг нэг ийм асуулт байгаад байдаг юм байна лээ. Би урьд нь очиж ажиллаж байсан. Тэгэхээр энэ дээр яагаад тийм өөр үнийн тэр ажил хийснийхээ төлөө ялгамжтай байдлаар тэр төлбөрөө авдаг энэ яагаад тийм байгаад байдаг юм. Энийг нэг хариулаад өгчихвөл зүгээр байгаад байна.

Хамгийн сүүлийнх нь тэр энэ хаягдалтай үйлдвэрээс гарч байгаа хаягдалтай холбоотой энийг тодорхой болгох хэрэгтэй шүү. Яг тодорхой болгох хэрэгтэй. Ийм ийм бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ гээд. Энийг яг бүүр тодорхой асуумаар. Яг юу хийх гэж байгаа юм. Барилгын салбар дээр автын юм уу, тэрийгээ аягүй тодорхой болгоод зарлаад явбал их зүгээр байгаад байгаа юм.

Гуравдугаарт гэх юм бол тэр яг одоо энэ манай Аж үйлдвэржилтийн байнгын хороо бол мэргэжлийн байнгын хороо. Аж үйлдвэрийн салбарт ажиллаж байсан олон хүмүүс байгаа байх. Тийм

болохоор энэ Байнгын хорооноос та хэдэд ямар бодлогоор дэмжлэг үзүүлбэл ажил өшөө хурдтай урагшлах гээд байна. Тэрийг нэг хэлээд өгчихвөл зүгээр байгаад байна. Би газар дээр нь очиж ажилласан хүний хувьд бол манай энэ зарим нэг яам, Тамгын газраас очоод тэр конвентынх нь системийг нь хүлээж авдаггүй. Зарим нэг хяналт шалгалтын газраас нь очоод хийгээд гүйцэтгэчихсэн ажлыг нь ингэж удаадаг нэг ийм төрийн дарамт бас энэ төрийн компаниуд дээр байгаад байна уу үгүй юу. Энэ дээр нэг тодорхой хариулт хэлээд өгчихвөл их зүгээр байгаад байна.

Хамгийн сүүлийнх нь энэ манай энэ Эрдэнэс Тавантолгойн энэ ажилчид маань өнөөдөр сэтгэл зүйн хувьд ямархуу байдалтай байдаг юм бэ? Аягүй их дарамттай байдаг юм шиг санагдсан. Очоод ажиллахаар. Тэгээд энэ дээр яг энэ холбогдох хүмүүс нь байгаа юм чинь нэг хариулт хэлээд өгчхөөрэй. Энд тэндээс нь дарамталдаг нүүдэг. Янз бүрийн л юм байдаг юм байна лээ. Яг очоод ажиллахаар. Тэгэхээр энэ дээр нэг хариулт өгчхөөч. Яг сэтгэл зүйн хувьд манай яг энэ асар их хэмжээний энэ.

С.Ганбаатар: Хариулт өгье. 7 номер. Нэр усаа хэлээд протокол бичиж байгаа учраас.

Х.Мөнхжаргал: Гишүүний асуултад хариулъя. Эрдэнэс Тавантолгой компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Мөнхжаргал. Эхний асуулт болохоор энэ жилийн 2024 оны Эрдэнэс Тавантолгой компанийн нийт борлуулалт 26 сая тонн нүүрсийг одоогоор борлуулаад байна. Үүний 13 сая тонн нь биржээр арилжигдсан байгаа. 40 гаран хувь нь бол биржээр арилжигдаж байгаа. Өнгөрсөн жил бол нийтдээ биржийн арилжаа бол эхэлснээс хойш 2023 оны 2 сараас эхэлснээс хойш 23 сая тонн нүүрсийг буюу өнгөрсөн жил 2023 онд 12 сая тонн, энэ жил 13.9 гээд. Ерөнхийдөө бол амны зарж байгаа харьцаа болон биржийн харьцаа бол биржийн харьцаа нь ер нь бол 50 хувь. Бид нар давуулах завил

зорилготой явж байгаа. Ер нь бол ам гэрээ гээд үндсэн манай 4 оффтейк гэрээ л явж байгаа. 2023 онд биржийн арилжаа эхэлснээс хойш нэг ширхэг ч амны гэрээ хийгээгүй байгаа. Дан бүх борлуулалтын гэрээ хэлцэл биржийн арилжаагаар хийгдсэн байгаа. Мөн тэр олборлолт Эрдэнэс Тавантолгой компанийн хамгийн том зардлыг эзэлж байгаа ААН Монгол Улсад татвар төлөгчид бол манай олборлолт хөрс хуулалтын компаниуд байдаг. Эдгээр компаниуд дээр болохоор анх бол онцгой дэглэм тогтоохоос өмнө бол нүүрсээр төлбөр төлдөг мөнгийг нь өгдөггүй зэрэг асуудалд байсан.

Анх томилогдож очихынхонд бол 80 гаруй тэрбум төгрөгийн өр үүсчихсэн компаниудын мөнгийг жил гаран өгөөгүй. Өгсөн нүүрс нь өөрөө чанаргүй нүүрс өгчихсөн зэрэг асуудлууд их байсан. Одоо бол энэ асуудлуудыг бүгдийг нь цэгцлээд тухайн компани өөрөө ажил гүйцэтгэсэн актаа үйлдсэн даруйд нь төлбөрийг нь сар сард нь шууд шилжүүлээд явж байгаа. Энэ асуудал дээр. Цанхийн зүүн уурхай дээр бол 14200, баруун дээр бол 13500 төгрөгийн өртөгтэйгөөр энэ ажлууд нээлттэй сонгон шалгаруулалтын хүрээнд компаниуд одоо сонгогдоод ажиллаж байгаа.

Ажилтнуудын тэр сүүлд асуусан сэтгэл зүйтэй холбоотой гээд байгаа юун дээр манай хүний нөөцийн захиргаа удирдлагын газрынхан ажиллаж байгаа. Бид нар энэ хүний нөөцийн бодлогыг бол анхнаас нь боловсронгуй болгох олон улсын жишигт хүргэх, стандартыг сайжруулах чиглэл дээр бол тодорхой ийм ажлууд хийгдэхээр төлөвлөөд явж байгаа.

Мөн тэр уртын ээлжээр явдаг 14, 14 явдаг асуудал дээр бид бүгд бол ямар нэгэн байдлаар тэр түрүүн ярьсан шинэ суурьшлын бүстэй холбоотойгоор 2025 оноос эхлээд ерөнхийдөө ажлууд хийгдээд явна аа.

Нийгмийн хариуцлагын хүрээнд Тавантолгой түши компанийн Засгийн газрын тогтоолоор Тавантолгой түши компанийн Энержи ресурсээс авдаг байсан эрчим хүчний нүүрсийг бол Эрдэнэс Тавантолгой хариуцахаар 2025 оноос эхлээд явж байгаа. Баярлалаа.

Хариулт дутуу байгаа юм байна шүү. Өөр ямар дутуу асуулт байна. 2 дугаар микрофон дээр.

Ө.Нямаа: Хаягдал дээр бол нарийн хаягдлыг л ерөнхийдөө ашиглах боломжтой. Тэрийг бол хөнгөн блок замын хавтан ерөнхийдөө хийдэг барилга чиглэл дээр зарим тохиолдолд бол технологиосоо хамаараад баяжуулалтын процессууд явагддаг байж байгаа. Ерөнхийдөө 3 чиглэлээр ажиллах боломжтой гэсэн үг.

С.Ганбаатар: Очирбат гишүүн тодруулъя.

Г.Очирбат: Тэгээд харин яг ингээд байгаа байхгүй юу? Биржээр нийт борлуулалтынх нь 40 хувь, 60 хувь нь гадуур, тэгээд 60 хувиа бас яг тодорхой оффтейкийн тэд шууд гэрээ нь тэд гэдгээ хариулахгүй үлдээчихлээ л дээ. Тэгээд энийгээ яг тодорхой хэлээд өгчихвөл их зүгээр байдаг юм шүү. Нэгт гэх юм бол.

Хоёрт гэх юм бол тэр Монгол компаниудыг харин яг ингээд байгаа гэсэн мэдээлэл ирээд байгаа байхгүй юу. Монголчууд ажил хийхлээр 13 мянга хэдэн зуугаар төлбөрөө аваад байдаг тэ? Адилхан ажил хийж байна шүү дээ. Нөгөө талд нь гаднынхаа ажил хийгээд 14, 15 мянгын ингээд төлбөр аваад байдаг. Тэгэхээр энэ нөхцөл байдал чинь эргээгээд тэнд ажил хийж байгаа ААН-үүдийн ард иргэдийн ААН-үүдийн ажилтан албан хаагч нарын итгэлийг ингэж унагаадаг юм байна лээ шүү. Тэрийг очиж ажиллаж байхад хэлдэг юм байна лээ шүү дээ. Тэгээд энэн дээрээ манай удирдлагууд анхаарч байна биз. Тэр хаягдлыг бүр яг тодорхой болгоорой. Яг барилгын энэ

материал гээд. Өнөөдөр эрчим хүчээ та хэд чинь урдаас явуулж байгаа тиймээ. Эрчим хүчний нөгөө 450 мегабайтын чинь эрчим хүчний эх үүсвэртэй болоод ирэх юм бол тэндээс гарах баяжигдаж их тодорхой байх хэрэгтэй.

С.Ганбаатар: Очирбат гишүүн үг хэллээ. Ингээд Пунсалмаа гишүүн асуулт асууя.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу? Энэ Эрдэнэс Тавантолгойн бүтээн байгуулалт сайхан томоохон бүтээн байгуулалт болжээ. Нэг их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт орсон байна. Түүрүү жил 2023 оны ноогдол ашгийг 2024 онд тараасан. Энэ томоохон бүтээн байгуулалт орж ирснээрээ ноогдол ашиг 2024 онд хэдэн төгрөг тарагдах юм. Одоо яг том бүтээн байгуулалт орсны дараа 2025 онд цаашидаа ер нь хэдэн төгрөг ноогдох юм бэ? Энэ ноогдол ашгийн талаар асууя, 1072 хувьцааны.

Хоёрдугаарт нь иргэдийн мэдэх эрхийг хангах үүднээс ер нь энэ том бүтээн байгуулалт өөрөө 1 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалттай хэдэн жилийн дараа энэ оруулсан хөрөнгө оруулалт нь нөхөх юм бэ? Энэ 2 дугаар асуулт.

Гуравдугаар асуулт нь ер нь бол энэ компани ТӨК явж байна. Цаашидаа нээлттэй компани болгож энэ хувьцаа эзэмшигч нар хувьцаагаа ноогдол ашгаа хэзээ авахаа мэддэг, хэдий хэмжээний ноогдол ашиг авахаа тооцдог үйл ажиллагаанд нь оролцдог, зардлыг буруулах орлогыг нэмэгдүүлэх дээр өөрсдийнхөө дуу хоолойг өргөдөг ийм нээлттэй компани болох ямар үе шаттай ажлууд хийгдэж байгаа вэ гэдэг ийм 3 асуулт асууя.

Тэгээд энэ дээр бас нэг их сайшаалтай зүйл нь шинэ суурьшлын бүс баригдаж байна. Эрдэнэт шиг тийм энд энэ залуучууд ажиллаж амьдарч болдог ийм сайхан бүс нээгдэж байгаа нь их

талархууштай байна. Тэгээд Монголчууд өөрсдөө бас энэ өөрсдийн хүч хөдөлмөрөөр ийм сайхан компани байгуулчихлаа. Ямар ч л байсан энийгээ ингээд олон нийтийн нээлттэй компани болгоод явах нь бол цаашидын Монгол Улсын ирээдүйд их хэрэгтэй. Энэ 3 асуултдаа хариулт авъя аа. Баярлалаа.

С.Ганбаатар: 7 номер хариулт өгье.

Х.Мөнхжаргал: Гишүүний асуултад хариулъя аа. Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Мөнхжаргал. Эрдэнэс Тавантолгой ХК нь 2024 оны 3 дугаар улирлын байдлаар буюу 9 дүгээр сарын 30-ны байдлаар 4.2 их наяд төгрөгийн балансын цэвэр ашигтай гарсан байгаа. Энэхүү өнөөдрийн танилцуулсан баяжуулах үйлдвэрийн нүүрсний төлбөр нийтдээ 84 хувь нь. Түрүүн хэлсэн 84 хувь нь хийгдчихсэн байгаа. Үлдэх 170 тэрбумын төлбөр бол 2025 он дамжаад гарах байх аа. Цаашидын ноогдол ашигийн хувьд бол компанийн цаашид баримтлах бодлого бол жил болгон ашигтай ажилласан жил болгондоо компанийн тухай хуулиараа ГҮЗ-ийн шийдвэрийнх нь дагуу ноогдол ашгаа жил болгон тараагаад явна. Тухайн жилийн ноогдол ашигийн яг дүнг бол 4 дүгээр улирлын буюу жилийн эцсийн тайланг эцэслэн гарсны дараа тодорхой болгох учраас хэлэх боломжгүй байна аа.

Гуравдугаар улирлын байдлаар бол ашигтай 4.2 их наядын ашигтай, 4 дүгээр улирлын байдлаар хүлээлтээр бол бид нар 5 их наядын ашигийн хүлээлттэй байгаа. Цаашид нээлттэй болох асуудал дээр бол Засгийн газрын шийдвэр гарсан. Засгийн газрын шийдвэр дээр манай Эрдэнэс Монгол толгой компани энэ дээр хамтраад ажиллаж байгаа. Нээлттэй болох энэ асуудал дээр компанийн зүгээс бүхий л хүч бололцоогоо дайчлаад ажиллах болно оо. Баярлалаа.

С.Ганбаатар: Далайн Батбаяр гишүүн асуулт асууя.

Д.Батбаяр: Сайн байцаана уу? Ажлын хэсгийнхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Нэлээн хэдэн асуулт асууна та бүхэн минь бичиж авчхаад дараа нь эргүүлээд ахиад бичгээр өгчхөөрэй. Аягүй бол хариулж амжихгүй байж магадгүй шүү. Тэгэхээр энэ дээр нөгөө юу байгаа гэхээр барилгын хяналт хийсэн байгууллагаас төлөөлөл байгаа билүү байгаа юу тиймээ? Тэгэхээр Норинко миний ойлгож байгаагаар та хэдийн явуулсан энэ мэдээллээс харах юм бол Норинко ТЭЗҮ-ийг нь хийгээд тэгээд ахиад Норинко бүтээн байгуулалтыг нь хийсэн байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм юм байж болдог юм уу? Та бүхэн одоодоо зураг хийсэн улсуудаа төлөөлөөд ахиад барилга барьсан улсуудаа шалгаад явсан юм байна. Тэгэхээр энэ барилга бүтээн байгуулалтын ажил бол яг стандартынх нь дагуу алдаа эндэгдэлгүйгээр цаашидаа олон жилийн хугацаанд ямар нэгэн алдаагүй ажиллахаар үргэлжилж ажиллахаар ингэж баригдсан уу гэдэг нэгдүгээр асуулт байна. Барилгын хяналт хийсэн улсууд.

Хоёрдугаарт нь энэ чинь бараг 1.87 их наяд төгрөгөөр баригдсан байна аа. Тэгэхдээ нийт хүчин чадлынхаа 3-ны 1 нь буюу 10 сая тонн нүүрс баяжуулах нь байна шүү дээ. Бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь тиймээ. Тэгээд энэ тоног төхөөрөмжийнх нь сонголтыг ер нь хэн хийсэн юм бэ? Би очиж үзсэн. Танай үйлдвэр дээр очиж үзэж байсан дандаа Хятадын тоног төхөөрөмжүүд байгаа харагдсан. Яг хажуухан талд нь байгаа үйлдвэрийг үзсэн. Нөгөө нэг Данийн ямар үйлдвэр байдаг билээ тийм үйлдвэр байгаа харагдсан. Тэгээд танай үйлдвэрийн тоног төхөөрөмжийн сонголтыг хэн хийсэн юм бэ? Энэ гэрээндээ их тусгахад хэн оролцсон бэ? Энэ үйлдвэрлэлийн ашигт ажиллагаа хэдэн хувь байх вэ? Энэ үед гэрээн дээрээ тоног төхөөрөмжүүд богино хугацаанд элэгддэг тоног төхөөрөмжүүдийн

нийлүүлэлтийг тусгаж чадсан уу гэдэг 2 дугаар асуулт байна.

Гуравдугаар асуулт нь цахилгааны эрчим хүч хангалтгүй байгаа гэсэн ойлголттой байгаад байгаа. Тэгэхээр энэ маань энэ дэд станц маань ахиж шинээр баригдах уу, хэзээ баригдаж дуусах вэ? Ирэх жилийн 3 дугаар сараас эхлээд нээлт хийнэ гэсэн. Тэгээд энэ үед бэлэн байх уу ямар нэгэн саад тотгор гарах уу гэдэг асуулт байна. Цахилгаантай холбоотой. Түрүүн Мөнхбаясгалан гишүүн асуусан. Тодотгоод дахиад асуучихъя. Нийт хэрэглэсэн усныхаа хэдэн хувийг нь цэвэршүүлээд дахиж ашиглах вэ гэдэг асуултад та бүхэн хариулаагүй. Энэ дээрээ хариулчхаарай. Ямар техникийн шийдэл байгаа вэ? Би олж харснаар тийм худаг тийм юу хараагүй нуур хараагүй, хиймэл нуур хараагүй байгаа. Тэгэхээр иүүд асгаад байдаг болж таарч байна уу яаж байна тэрийгээ нэг тодруулаад хэлчхээрэй

Тавдугаарт нь түрүүн ярилаа. Оффтейк гэрээг нэгийг нь ойролцоогоор нэг тонныг нь 77 орчим тонноор тооцож оффтейк гэрээ хийсэн гэж ойлгосон. Миний хэрвээ мэдээлэл зөв бол өдийд зах зээл дээр бол 160 орчим долларын үнэтэй зарагдаж байгаа нүүрс маань коксожсон нүүрс маань 160 орчим доллароор зарагдаж байгаа. Тэгэхээр чинь үнийнхээ бүтээгдэхүүнийхээ 50 хувиар нь оффтейк гэрээ хийсэн, бууруулж оффтейк гэрээ хийсэн болж таарч байна. Энэ зөв үү? Би нягтлаад асуучихъя.

Зургаадугаарт нь хүний нөөцтэй холбоотой асуудал. Яг танай хажууд чинь ажиллаж байгаа.

С.Ганбаатар: Батбаяр гишүүнд тодруулга нэг минут өгье.

Д.Батбаяр: Яг танай хажуу талд байгаа Ухаа худгийн баяжуулах үйлдвэр маань 15 сая тонн илүү хүчин чадалтай танайхаас 50 хувиар тэнд 140 орчим хүн ажиллаж байгаа. Тэгэхээр танай дээр

400-аас 500 орчим хүн шинээр ажлын байр бий болно гэж байна. Тэгээд энэ оновчтой шийдэл мөн үү? Танайх орчин үеийн тоног төхөөрөмжөө автоматжуулсан гэж ярьсан. Тэгэхээр яагаад ингээд энэ 3 дахин илүү хүн амьтан ажиллах болчихоо. Энэ төрийн өмч гээд ийм их ажлын байр бий болоод байна вэ гэдэг асуулт байна. Эдийн засгийн хувьд хэр ач холбогдолтой вэ гэдэг асуулт байна.

Долоод нь бол энэ нөөцтэй холбоотой асуудал байна. Танай нийтдээ орж ирж байгаа энэ тэжээлийнхээ чинь бараг 20, 30 хувьд энэ 35 хувийг нь 20 хувийн үнсний агуулгатай гэгчихсэн байгаа байхгүй юу. 30 хувьдаа ахиад энэ дээр чинь нийтдээ 50 хувь нь 20 хувийн үнсний агуулгатай гэсэн мөртөө гарч байгаа бүтээгдэхүүнийх нь үнсний агуулга нь аягүй багасчхаад байгаа байхгүй юу. Тэгээд үнсийг нүүрс болгочихдог болчихсон юм болов уу? Энийг нэг технологийнх нь хувьд тайлбар тайлбарлаад өгчхөөч ч.

С.Ганбаатар: Батбаяр гишүүнд дахиад нэг минут өгчихье. 2 удаа сунгах ёстой ингээд яаж байгаа нэг минут өгөөд асуултаа тодруулж асууя.

Д.Батбаяр: Ахиад би дэлгэрүүлээд тайлбарлачихъя. Орж байгаа тэжээл дээр чинь орж ирж байгаа бүтээгдэхүүний чинь үнс нь маш их байгаад байгаа. Гарч байгаа бүтээгдэхүүний чинь үнс нь маш бага байгаа 17 орчим хувь байгаад байгаа. Энэ яг технологийн ийм сайн шийдэл байна уу гэдгийг би асуучихмаар байгаад байгаа юм. Сүүлийн асуулт нь юу вэ гэхээр энэ нүүрсний нөөцтэй холбоотой асуудал байгаад байгаа юм. Юу вэ гэхээр танай нөөцийн чинь тал хувь нь эрчим хүчний нүүрс байгаа шүү дээ. Миний ойлголтоор зөв бол өнөөдөр Монгол Улс маань нэг 60 гаруй сая тонн нүүрс зарсан байгаад байгаа. Тэрний бараг жараад сая нь буюу 90-ээд хувь нь бол дандаа коксожсон нүүрс байгаад байгаа эрчим хүчний

нүүрсний борлуулалт маш бага байдаг. Тэгэхээр танай нөөцийн чинь тал хувь нь эрчим хүчний нөөц байгаа урт хугацаандаа ямар бодлого барих вэ, энэ нөөцөө яаж ашиглах вэ гэдэг ийм асуултууд байна аа. Тэгээд бүгдийг нь бичиж байгаад бүгдийг нь бичгээр авна шүү гэдгээ хэлчихье.

С.Ганбаатар: Хариулъя хэдэн номерын 8 номерын микрофонд хариулъя. Их тодорхой асуултаас асуулаа.

Г.Ган-Өлзий: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Батбаяр гишүүний 1 дүгээр асуултад Барилгын хөгжлийн төвийн захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч талын менежер Ган-Өлзий байна. Батбаяр гишүүн яах вэ ТЭЗҮ-ийн оролцоон дээр зохиогчийг асуулаа. Тэгээд яах вэ Барилгын хөгжлийн төв техник хяналт хийхдээ магадлалаар батлагдсан. Зураг төслөөс хойш тухайн зураг төслийн дагуу норм стандарт дүрмийн дагуу хийгдэж байгаа ажил дээр хяналт тавиад ажиллаж байгаа. ТЭЗҮ дээр энэ дээр зураг төсөл дээр Норинко Дайди түншлэл түлхүүр гардуулах гэрээтэй деталь зураг төсөл дээр ажиллаж байгаа. Интеллек тауэр гээд Монгол талаас зураг төслийг баталгаажуулаад ажиллаж байгаа. Энд зураг төслийн ажлууд дээр техник хяналт хэрэгжүүлж явж байгаа. ТЭЗҮ-ийн оролцоог манай захиалагч талаас хариулна.

С.Ганбаатар: 8 номерын микрофоныг дахиад нээе. Тодорхой хариулаарай.

Г.Ган-Өлзий: Захиалагчийн хяналтын багийн зүгээс 2 ростероор нийтдээ 78 инженер техникийн ажилтнууд байнгын хяналт тавьж ажиллаж байна. Яг зураг төсөл, техникийн шаардлага, гэрээний шаардлагыг бүгдийг нь хангуулж ажиллаж байгаа. Өнөөдрийн байдлаар төсөл маань 90.5 хувийн гүйцэтгэл нь баталгаажчихсан, 95.5 хувь дээр гүйцэтгэлийг нь хяналт шалгалт,

баримтжуулалтыг нь шалгаад явж байна. Тэгээд ер нь бол яг инженерийн техникийн бүх асуудлуудыг хянаж шалгаад нийцэж байгаа тохиолдол нь баталгаажуулаад явж байгаа.

С.Ганбаатар: Нэмж 2 номерын микрофоныг нээж өгье, нэмж хариулъя.

Ө.Нямаа: Сайн байцаана уу? Нүүрс аж ахуй үйлдвэрийн газрын дарга Нямаа байна аа. Энэн дээр хариулт өгье өө. ТЭЗҮ-ийг бол Чайна металлуржикал инженеринг компани". /СМЕС/ гээд компани хийсэн байж байгаа. Тийм СМЕС гээд тэр нь бол Монголын уул уурхайн хүрээлэнтэй хамтарч хийсэн. Энэ дээрээ технологи болон тоног төхөөрөмжийн сонголтуудыг хийсэн байдаг аа. Норинко бол хийгээгүй. Норинко бол тухайн нөгөө нэг ЕРС буюу түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг зураг төсөл барилга угсралтын ажлыг бол хийхээр бол Дажи Инженеринг гэдэг компанитай хамтран аваад энэнийхээ дагуу хийж байгаа. Захиалагчийн хяналтыг бол Барилгын хөгжлийн төв хариуцан хийж байгаа. Тэгээд тоног төхөөрөмжийн хувьд бол хөдөлгүүр бол жишээлбэл АВВ үндсэн дээр тоног төхөөрөмжүүдийн бол Аурю гээд Австралийн брэндүүд байж байна. Тоног төхөөрөмжийн сонголтууд бол гэрээн дээрээ ч байдаг. Дэлхийн эхний 3-д орох брэндүүдийг ерөнхийдөө сонгож оруулна гэсэн байдаг. Эхний нэгд орж байгаа.

С.Ганбаатар: 2 номер.

Ө.Нямаа: Тийм. Баяжуулалтын тоног төхөөрөмж нь бол Оюу Толгойд хэрэглэж байгаа Хай ван гээд брэнд байдаг. Тэр үндсэн циклон буюу нийлүүлж байгаа. Тэр нь бол манай нийт бүтээгдэхүүн 70 хувийг баяжуулдаг хэсэг дээр нь энэ явж байгаа. Оюу Толгойтой адилхан. Тэгэхдээ энэний үйлдвэрлэгч нь бол Хятад. Гэхдээ Хятад байлаа гээд муу биш. Дэлхийд Оюу Толгой дээр хэрэглэж байгаа гэж үзсэн учраас.

Тэгээд дараагийн тоног төхөөрөмж нь бол TBS гээд тоног төхөөрөмж. Тэр нь бол мөн адил бол Хай ван гэж байна. Гол нийт тоног төхөөрөмжүүдийн юуг бол Аурю гээд тод нэлээд Австралийн компани байж байгаа. Шигшүүр болон ангилах хэсгүүдийг бол нийлүүлсэн. Цахилгааныг АВ, Теко, Семенс гээд брэндүүд байж байгаа.

Дараагийн асуулт нь тэжээлтэй холбоотой асуудал дээр хариулт өгье. Тэжээл бол ингээж байгаа юм. Үнслэг бага байх тусмаа сайн чанартай гэсэн үг. Тэгэхээр баяжуулах үйлдвэр маань өөрөө үнслэг өндөртэй буюу шатах хольц үндэслэг гэдэг маань өөрөө шатах хольцыг илэрхийлдэг. 20 хувийн.

С.Ганбаатар: Их олон асуултад хариулаагүй дутуу хариулчих шиг боллоо. Бичгээр бүгдийг нь Далайн Батбаяр гишүүнд хүргэж өгнө шүү. Энэ дээр яах вэ дүрэм нь 4 минутад хариулна тэгээд 1 минут тодруулна гэж байгаа. Тэрийг нь тодруулаад хариул даа чухал асуулт. 7 номер.

Х.Мөнхжаргал: Баяжуулах үйлдвэрийн хүний нөөц түрүүн 400 гаруй ажилтан гээд тэгсэн яах вэ энэ нөгөө ростероороо 14, 14 талдаа гэж тэгж гарч байгаа юм. Яах вэ, орон нутаг, орон нутгаасаа бид нарт 5, 2-оор ажиллуулаад явах цаашидаа тийм бодлогыг үлдсэн орон тоон дээрээ зохион байгуулаад явна. Ухаа худгийн баяжуулахын үйлдвэрийн маань бол 14, 7-оор явж байгаа. Мөн суурьшлын асуудал нь тэндээ шийдэгдсэн байдаг. Ийм ялгаатайгаар нь хүний тооны зөрөө гарч байгаа. Энэ дээр бол бид цаашидаа хүний нөөцийнхөө бодлого дээр анхаараад явна аа. Баярлалаа.

С.Ганбаатар: 2 номерын микрофон.

Ө.Нямаа: Нийт 472 хүний бол 100 гаруй нь бол инженер техникийн биш ажилчид байгаад байгаа юм. Энержи

ресурс компанийн нүүрс баяжуулах үйлдвэр дээр бол 180 орчим инженерийн техникийн ажилчид байгаа гэсэн үг. Тэр харилцан адилгүй байгаа нь болохоороо нөгөө нэг тэр компанийн бүтэц зохион байгуулалттай ойролцоо ялгаатай. Тэгээд ээлжийн нэг нь болохоор 4 ээлжийн бүтэц зохион байгуулалттай нөгөөх нь 3 ээлж, 4 ээлжийн хосолсон зохион байгуулалттай болохоор хүний хувьд жоохон юу байгаа ялгаа гарч байгаа.

Дээрээс нь манай баяжуулах үйлдвэр нь болохоор агуулахын системүүд байгаа учраас тэрэн дээр тодорхой хэмжээний нэмэлт инженер техникийн ажилд орохоор байгаад байгаа. Тэгээд энэ дээр Загийн ус болон дэд станцын ажилчид нэмэгдэж байгаа гэсэн үг. Энержи Ресурс компани дээр бол Загийн устай адилхан нөгөө нэг усны систем болон бусад юунууд нь болохоороо бүтэц нь тусдаа байдаг. Нийт хүнийх нь тоо миний санаж байгаагаар 1600-аад орчим хүнтэй компани нийтээрээ.

С.Ганбаатар: Ингээд бусад тодруулах зүйлүүдийг нь бичгээр өгөөрэй. Гишүүд асуулт асууж дууслаа. Дараа нь үг хэлнэ.

Би тодруулах хэдэн зүйл байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ТНБД Жавхланбаатар дарга ирсэн байна. Би нэг тодруулах асуулт 1 дүгээр асуулт. Нүүрснээс Монгол орон хамааралтай байна. Аж үйлдвэржилт эрдэс баялгийн яам ч гэсэн хамааралтай болсон. Тэгэхээр нүүрсний үнэ ирээдүйд энэ 2025, 2026, 2027 онд ямар прогностой байгаа вэ? Нүүрс унасан нүүрсний үнэ харьцангуй янз бүр болсон тохиолдолд энэ үйлдвэрлэлийг Тавантолгойн энэ нүүрсний энэ үйл ажиллагаан дээр нөлөө орох уу? Энэ прогноз энэ үйл ажиллагааны төлөвлөгөөг нарийвчилж боловсруулсан зүйл байгаа юу? Энэ дээр би тодруулж асууж байна.

Хоёрдугаар асуулт Мөнхжаргал даргаас асууцхъя.

Эрдэнэс Тавантолгой нүүрсний энэ чинь тэгээд л баян шүү дээ. Тэгээд л ерөөсөө дээр дооргүй л нүүрсний гэрээ өгөөч гээд л, гуйгаад л, гуйлга гуйгаад л Монголд ер нь хамгийн чухал хүн болчихоод л яваад байна шүү дээ та нар чинь. Нүүрсний гэрээ гэдэг нэг ид шидтэй юмны цаана л нэг л бөөн цөм цөм ашиг авлигал байдаг бололтой л юм яригдаад байна. Асуулт маань юу вэ гэвэл энэ авлигал эрх ашгийн энэ янз бүрийн сонирхлын зөрчлөөс хамгаалагдсан механизмуудаа та нар боловсруулж энэ Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр оруулж ирэх боломж байгаа юу? Яагаад гэвэл ер нь миний мэдэхийн бараг ихэнх дарга нар чинь энэ Тавантолгойн дарга нар шоронд явлаа шүү дээ. Улс төрийн дарамт шахалт улс төрийн янз бүрийн лобби зовлон зүдгүүрүүд байдаг. Энэ дээр нэгэнт аж үйлдвэржилт дээр энэ бэрхшээл үүсэж байгаа тохиолдол гарц гаргалгаанууд байгаа юу? Энэ чигээрээ чимээгүй яваад байх уу? Мэдээж нөхцөл сайжирч байгаа. Миний 2 дугаар асуулт энэ.

Энэ нүүрсний гэрээ гэдэг энэ ид шидийг алга болгож байгаа юм байгаа юу?

Гуравдугаар асуулт ер нь бол 7 асуулт байдаг. Тэгээд ер нь би 2 асуултдаа л хариулт авчихъя. Зүгээр гишүүддээ хандаж хэлэхэд Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан хяналт шалгалтын ажлын цаглаварт Байнгын хорооноос санал оруулж байнгын хорооны гишүүдээ оролцуулаад Эрдэнэс Тавантолгой компани дээр газар дээр нь танилцах нарийвчилсан мэдээллүүдийг авахгүй бол ер нь танин мэдэхүйн хариултаар л аргалаад байна шүү та нар. Энэ олон тендер. Миний 3 дахь асуулт. Энэтэйгээ холбогдуулж би асууя. Би бол Байнгын хорооны даргын хувьд энэ саяынхыгаа шийдчихсэн. Энэ олон тендерүүдийг

бүгдийг нь ил тод нээлттэйгээр үйл ажиллагаа явцын хяналт шалгаруулалтын хяналтуудыг ил тод веб сайт дээрээ бүгдийг нь тавьж чадаж байгаа юу, тавьж байгаа юу? Ийм 3 асуулт асууя. Жавхланбаатар дарга 8 дугаар микрофон дээр байна уу?

С.Жавхланбаатар: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам. Нүүрсний бид нар хамааралтай байгаа гэдэг маань бол үнэн. Манай нийт 69 сая 10 сарын гүйцэтгэлээр 69 сая тонн нүүрс коксжих нүүрс экспортлоод байж байна.

Нүүрсний үнийн прогнозыг бол бид нар 2 жилээр түрүүн эдийн засгийн ерөнхий нөгөө төлөвлөлт төсвийн өмнө ороход Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлсэн байж байгаа. Прогнозоо бол өгсөн. Ерөнхийдөө бол өнөөдрийн хани маань буурах төлөвтэй байгаа. 2 жилдээ Сангийн яамны төсөв дээр авсан тооцоолол маань Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны тооцооллоос харьцангуй өндөр гарсан. Бид нар 135 доллар дээр санал өгсөн боловч 150 орчмоор бол тооцоолол авсан байгаа. Юун дээр төсөв дээр. Ер нь бол бид нар тогтмол нүүрсээ хэрхэн борлуулах вэ? Үнийн бууралтаас яаж хамгаалах вэ гэдэг маань нүүрс, коксжих нүүрс маань өөрөө урт хугацааны энэ гэрээтэй бас их холбоотой байгаа. Хэдийгээр бид нар биржээр өндөр үнэ гэж зарж байгаа боловчиг худалдан авагч тал маань урт хугацаанд гэрээ байгуулахыг сонирхдог Хятадын худалдан авагчид маань. Цаад шалтгаан нь мэдээж энэ гангийн үйлдвэрийн өөрийнх нь тогтмол нийлүүлэлттэй холбоотой байгаа. Ийм учраас Засгийн газар дээр өнөөдөр бас хэлэлцэгдээд явж байгаа Байнгын хороодоор орж ирэх байх. Бид нар Чайна Энержи компанитай урт хугацааны нүүрс борлуулах гэрээний асуудал хөндөгдөөд явж байгаа.

С.Ганбаатар: Мөнхжаргал дарга 7 дугаар микрофон.

Х.Мөнхжаргал: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Нүүрсний гэрээ бол ерөнхийдөө түрүүн хэлсэн 2023 оноос эхлээд биржийн арилжаагаар хийгдээд зөвхөн биржээр борлуулсан нүүрсний гэрээ хийгдэж байгаа. Энэ дээр өмнө нь байгаагүй нэг хууль, нэг журам бид нар дагаж мөрдөж байгаа. Өмнө нь болохоор Биржийн тухай хуулийг 1 дүгээрт дагаж мөрдөж байна.

Хоёрдугаарт Монголын хөрөнгийн бирж бол энэ биржийн арилжаа давхар хяналт тавьж байгаа татвар, гаалийнхан маань бас давхар хяналт тавьж байгаа. Биржийн арилжаанаас өөр төрлөөр хийгдсэн гэрээн дээр ямар нэгэн тийм гаалийн нэвтрүүлэхгүй ч юм уу татварын асуудал хийгдэхгүй ийм болсон байгаа. Мөн Эрдэнэс Тавантолгой компанийн сайт дээр бид нээлттэй уурхай гээд булан нээсэн. Энэ булан дээр бол ерөнхийдөө манай компанийн байгуулагдаж байгаа.

С.Ганбаатар: Тодруулж нэг минут өгье. 7 дугаар микрофон.

Х.Мөнхжаргал: Гэрээний мэдээлэл болон тээвэр, экспорт Си зөвшөөрөл болон бусад ийм арилжаатай холбоотой бүх мэдээллүүд ил тод нээлттэйгээр байршиж байгаа. Худалдан авалтын хувьд бол бүх худалдан авалтууд төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд хийгдэж байгаа. Тэр хуулиараа Сангийн яам шалгалтаа хийгээд шаардлагатай бол бусад эрх барих байгууллагууд бол бүгд яг тэр хуулийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналтаа тавиад явж байгаа. Баярлалаа.

С.Ганбаатар: Би ингээд үндсэндээ асуултаа авлаа. Ерөнхийдөө ний нуугүй хэлэхэд одоо ингээд бирж гээд нэг гайгүй шиг нааштай юм болоод юм наашилж байгаа. Тэгэхдээ л сорчлоод л агуулга дээр нь, чанар дээр нь мафиуд нь ажиллаад эхэлчихсэн л гэдэг. Бид чинь мэдээлэл авна

шүү дээ. Тэгэхлээр энэ болгоныг нягталж газар дээр нь шалгах шаардлага байгаа. Түрүүн ярьсан 3 дугаар улиралд 4.3 их наядын ашигтай ажиллаж байгаа. Одоо энэ 4 дүгээр улиралд бол 5 их наядын ашигтай ажиллана гэж байгаа. Гэтэл борлуулалт нь 9.6 их наяд үндсэндээ зардал нь энэ 3 дугаар улирал гэхэд л 5.3 их наяд гэсэн үг шүү дээ. 5.3 их наядын зардал гаргаад бид чинь нүүрс үйлдвэрлээгүй шүү дээ. Газар доор өвөг дээдэс маань бидэнд үлдээсэн гэж ойлгож болно. Энийгээ л ухаж гаргаж байгаа. Тэгэхээр энэ дээр тодруулах 7.2 сая тонныг 3 дугаар улиралд гаргасан байна.

Нарийвчилж хэдүүлээ бас улам үр дүнтэй ажиллах талаар хамтран ажиллана аа. Ингээд үг хэлэх гишүүд кнопоо дарна уу. Үг хэлэх гишүүд байна уу. Ингээд Бадамсүрэн гишүүнээр үг хэлэх гишүүдийг тасаллаа.

Ингээд Мөнхбаясгалан гишүүн үг хэлнэ ээ.

Л.Мөнхбаясгалан: Загийн усны хоолойн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг би сая хараад сууж байна Одоо яг энд хараад сууж байна. Та бүгд бол их ашигтай ажиллах, Монгол Улсад их ач тустай сайхан үйлдвэр нээсэн чинь бол үнэн. Энийг барьж ашиглалтад оруулсан. Энэ бол Монгол төрийн бодлого. Гэхдээ байгаль орчны эрсдэлийн менежментийн төлөвлөгөө чинь үнэхээр гомдмоор байна аа. Энд танайд бичиж өгснөөр бол жилдээ 67.7 сая долларын цэвэр ашиг олно. Тэгээд гаргасан зардлаа долоохон жилийн дотор төлнө гэсэн байна. Тэгсэн хэрнээ байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл ялангуяа усгүй болгох аюултай гээд бүүр энэ байгаль орчны үнэлгээ нь улаан өнгө өгсөн байна шүү дээ энэ дээр. Мааш их бохирдол өгнө. Усгүй болгоно, нөхөн сэргээлт хийх ёстой гээд. Тэгсэн чинь та нарын нөхөн сэргээлт хийж байгаа юм чинь ямар ч мөнгө тавиагүй байна шүү дээ. Тэрбум мод төсөл дээр нэг 15 сая төгрөг тавьсан байна. Өөр бас нэг

14 саяар мод л тарих юм байна. Тэгээд нөгөө усан дээрээ 14 худаг гаргачаад тэрэн дээрээ тоолуур л тавих юм байна. Ингэж болохгүй шүү дээ. Та нар залуу хүмүүс шинэ үе ирж байна. Ингэж байгаль орчныг хохироож болохгүй шүү дээ. Одоо тэр Загийн усыг хэрвээ байхгүй болгоод тэр чинь алтан ой, мөнгөн ой гэж явдаг маш үзэсгэлэнтэй газар. Тэр загийн усны уснаас ус татаж байгаа тэрэн дээрээ ямар ч нөх нөхөн сэргээлт юу ч байхгүй. Ямар ч үнэлгээ тавиагүй байна шүү дээ. Сийрст багийн өчнөөн айлыг нүүлгэн шилжүүлсэн. Нүүлгэн шилжүүлэлтийн мөнгө нь нэг үсрээд 10 сая л төгрөг байгаа. Тэр хүмүүсээс ажилд авч байгаа юу. Эрдэнэс Тавантолгойд ерөөсөө ажилд орж чадахгүй байна гээд Цогтцэций сумын иргэд маш их гомдолтой байдаг. Цогтцэций сум бол Монгол Улсад уул уурхай ашигласны үр дүнд нутгийн ард байгаль орчин яаж хохирч байгаагийн тод жишээ бүүр дэлхийн тод жишээ болсон сум байхгүй юу даа. Тэгээд та нар энэ байгаль орчны менежментийн төлөвлөгөөн дээрээ дахиж юм оруул аа. Энэ талаар болохгүй бол танайд шалгалт хийж бүүр хянан шалгах түр хороо ажиллуулмаар санагдчихлаа. Байгаль орчны үнэлгээ гэдэг зүгээр нэг цаас биш шүү дээ. Бичиг баримтын бүрдүүлэлт биш. Тэгээд Сийрст багийн тэр уур амьсгалын өөрчлөлтөд зориулж та нар юу хийх юм? Яагаад төлөвлөгөөн дээр чинь ийм юм байхгүй байгаа юм? Мөнгө олох нь олно. Гэхдээ бид нарт байгаль орчинд дахиж хэзээ ч нөхөгдөхгүй, говийн ус дахиж хэзээ ч нөхөгдөхгүй. Тэнд оршин сууж байгаа иргэд эхнээсээ бүр багаараа нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдчихсан байхгүй юу.

Тэгэхээр би тэр манай Цогтцэций сумын иргэдээс тэр айлуудаас тэндхийн мэргэжилтнүүдээс ажилд аваарай.

Дээрээс нь та нар байгаль орчныхоо энэ менежментийн төлөвлөгөөгөө сайжруул. Загийн усыг ширгээж болохгүй шүү л гэж хэлье. Энэ

тал дээр эргэж төлөвлөгөө танилцуулаач? Миний нэр дээр 48 цагийн дотор манай хуулиар 48 цагийн дотор надад энэ талаар эргэж мэдэгдэх үү бичгээр. Баярлалаа.

С.Ганбаатар: Энхтуяа гишүүн үг хэлье. Мөн Уянга гишүүнийг үгэнд оруулаарай.

Д.Энхтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе.

Ер нь бол маш Монгол Улсын энэ эдийн засгийн хөгжилд чухал үүрэг рольтой ийм үйлдвэр барьж байгуулаад бидэнд танилцуулга хийж байгаа та бүхэнд баярлаж талархаж байна. Тэгээд цаашидын ажилд нь амжилт хүсье. Тэгээд миний хэлэх гэж байсан санаа Мөнхбаясгалан гишүүнтэй давхцаж байна аа. Тэгэхээр өнөөдөр говь нутгийн энэ усан хангамжийг усны асуудал маш хүнд байдалтай байгаа. Тэгээд энэ усан хангамжийг нэмэгдүүлэх ийм олон янзын төслүүд явж байгаа. Тэгэхээр түрүүн одоо нэгэнт та нарын энэ гаргаж ирсэн энэ төсөл дээр энэ усны асуудал дээр бол маш эмзэг хандсан.

Дээрээс нь усны асуудлыг нэмэгдүүлэх ийм төсөл төлөвлөгөө үнэн үнэхээр байхгүй байгаад харамсаж байна аа. Тийм учраас ер нь бол энэ манай Байнгын хорооноос холбогдох энэ Засгийн газарт үүрэг чиглэл өгөх, хамтарч ажиллах, дээрээс нь судлах ийм асуудлыг оруулбал яасан юм бэ? Үүн дээр маш тодорхой санал юу гэхээр Хэрлэн тоонот төслийг бол мэдээж Оюу Толгой санхүүжүүлнэ гэж ингэж ярьж байгаа боловч энэ асуудал маш удааширалтай ер нь бол хэцүү байдаг шүү дээ. Ганбаатар дарга өөрөө маш сайн мэдэж байгаа. Тийм учраас энэ төслийн үр өгөөжийг Хэрлэн тоонот төсөлтэй уялдуулаад тодорхой ажлуудыг Байнгын хорооноос үүрэг даалгавар өгөөд энэ Хэрлэн тоонот төслийг хурдлуулах үр өгөөжийг нэмэгдүүлэх ийм саналыг миний хувьд гаргаж байна аа. Тэгэхээр энэ говийн

асуудал бид нар хэдийгээр маш гол эдийн засгийн эргэлтэд оруулах ийм том төсөл байгаа ч гэсэн нөгөө талаараа энэ усны асуудал бол гамшигийн хэмжээнд оччихсон байгаа. Энэ дээр нэг хэдэн гишүүн орилж чарлаад байх биш. Энэ дээр бол бүгдээрээ нийлээд хамтаараа энэ Хэрлэн тооно төслийг л хурдлуулах энэ асуудлыг бид нар Байнгын хорооноосоо нэлээн энэ шийдвэртэй алхмуудыг хийж Засгийн газарт холбогдох байгууллагуудад үүрэг даалгавар өгөх ёстой байх гэж ингэж бодож байна.

Хоёр дахь нь бол яах аргагүй энэ том төсөл дээр ажиллах нарийн мэргэжлийн инженер техникийн ажилчдын асуудал бол маш хүндрэх байх шүү. Одоо бол хэдийгээр яах вэ барилга байгууламж ерөнхийдөө энэ ажлыг хийхдээ хүмүүс ажиллаад явсан гэсэн. Сая энэ мэдээллийг харлаа. Цаашид энэ том үйлдвэрийг авч явах энэ том төслийг авч явах нарийн мэргэжлийн энэ хүмүүсийг Монголын мэргэжилтнүүдээ бэлтгэх асуудал дээр бас танай компани анхаарал хандуулж том төсөл төлөвлөгөө боловсруулах шаардлагатай байх гэсэн ийм 2 санал байна аа.

С.Ганбаатар: Ингээд Энхтуяа гишүүн сая санал гаргалаа. Манай Байнгын хорооны гишүүд энэ хуралдааны дараа 5 минут ажил хэргийн зөвлөгөөн байгаа шүү. Ингээд Уянга гишүүн үг хэлье.

Б.Уянга: Даргад баярлалаа. Байгалийн ухааны салбарын хүн учраас энэ газрын доорх ус дээр энд хэлэгдээд яригдаад байдаг таашаа мэдээллийг залруулах ёстой учраас ингээд нэрээ оруулаад хэлж байгаа юм аа. Газрын доорх ус бол нөхөн сэргээгддэг баялаг. Өнгөрсөн хугацаанд говийн бүсэд 8 жил дараалаад ган гачиг болчихсон учраас хөрсний ус сэргээгдэхгүй байсан. Тэгэхээр чулуулгийн орон зайгаар ус нь нэвчээд доошоогоо ордог ийм асуудал байдаг. Хоорондоо газрын доорх усны үе давхаргууд хоорондоо холбоотой байдаг.

Бүр гүн рүүгээ унданд хэрэглэж болохгүй хүнд уснуудыг үйлдвэрлэлд ашиглах нь зөв өө. Түрүүн Алтанбагана гээд эдний яг инженер нь хариулж байна шүү дээ тиймээ? Бид нар бүгдээрээ энийг яг таг ойлгоод авах хэрэгтэй. Яг энэ Тавантолгойн орчмоор газрын доорх усны судалгаа хангалтгүй хийгдсэн байдаг аа. Улаанбаатар хотод гэхэд л бид нар газрын доорх усаа ууж хэрэглэж амьдардаг. Гэхдээ бид нар гадаргатай ойрхон усыг авдаг учраас унданд хэрэглэж болдог. Говийн бүсэд байгаа тэр давстай усыг эрх хэрэглээнд нэвтрүүлэх нь зөв өө. Ус бол нөхөн сэргээгддэг баялаг юм аа.

Тэгэхээр одоо эрдэмтдийн дуу хоолойг л энэ дээр сайн оролцуулах хэрэгтэй байна. Хэрлэн тооно төсөл угаасаа мөрийн хөтөлбөрт орчихсон Орхон Онги бас орчихсон. Эд нар маань ингээд хэрэгжээд явна. Гэхдээ газрын доорх усныхаа судалгаа энийгээ орд болгох дээр усны судалгааны шинж чанарыг нь сайн мэдэх дээр Эрдэнэс Тавантолгойн хамт олон сайн ажиллах хэрэгтэй. 2025 онд мөнгө тусгасан байгаа 100 км-ийн радиуст гүн рүүгээ харах гэж байгаа бол энэ бол давуу тал шүү. Тэгээд удахгүй яах вэ Их Хурал дээр усны ажлын хэсгийг ахалж байгаагийн хүрээнд энэ үйлдвэрлэлд ашиглаад байгаа усны шинж чанар дээр амталгаа явуулья гэж төлөвлөж байна. Энэ болохоор яг энэ үйлдвэрт ашиглаж байгаа уснуудыг бид нар өөрсдөө амсаад л үзэх хэрэгтэй. Маш их давстай маш их өндөр эрдэсжилттэй хэрэглэж болдоггүй ус байдаг. Тэгээд нэгэнт мэдэхгүй зүйл байгаа учраас мэдэж авахын тулд судалгааг нь дэмжиж хийлгэх хэрэгтэй. Энэ дээр бол эрдэмтдийг уриалж оролцуулах бүх төрлийн байдлаар нь тусалж дэмжихэд бэлэн байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Үндэсний геологийн алба гээд агентлагаараа дамжуулаад газрын геофизикийн судалгаа бол хийлгэж байгаа. Тэндээ цахилгаан соронзонгийн аргаар газрын доорх усны байдлыг нь судалдаг ийм хариу үр дүн удахгүй гарах ёстой. Тэрийг энд Намчин дарга байгаа

учраас энийг нь авч байгаад судалгаагаа маш сайн эрчимтэй явуулаарай гэдгийг үүрэгжүүлбэ ээ.

С.Ганбаатар: Б.Уянга гишүүнд баярлалаа. Ингээд Д.Энхтүвшин гишүүн үг хэлнэ.

Д.Энхтүвшин: Би энэ экспортын бүтээгдэхүүний энэ өртөг нэмэгдүүлж байгаа энэ үе шатуудыг ер нь бүгдээрээ анхаарах ёстой энэ чиглэл дээр үг хэлэхийг хүсэж байна.

Тэгээд ялангуяа энэ оройд нь магнайлж байгаа уул уурхайн салбар ч гэсэн яг энийг бүтэн зургаар нь харахгүй бол хил давчхаад хилээс цааш жишээлбэл өөрсдөд нь хамаагүй юм шиг ингэж хаяж болохгүй. Бид нар нэмж олборлохгүйгээр илүү мөнгө олох боломж тэнд байна. Тэгэхээр энийг яаж олох вэ гэдгийг ажилламаар байна. Тэгэхээр энэ бодлогогүйгээсээ болоод жишээлбэл манайх их гарах тусмаа манай нүүрснүүд хоорондоо өрсөлдөж байна. Өөрөө өөрийнхөө нүүрстэй өрсөлдөж байна. Одоо энэ оффтейк гэж гэрээнүүд хийгээд энэ оффтейк хямдралтай авсан гэрээнүүд чинь нөгөө талдаа гараад энэ биржээр зарсан үнэтэй чинь өрсөлдөж байна. Өөрөөр хэлбэл биржээр илүү өндөр үнээр зарах бололцоо боломжоо өөрсдөө нэг гараараа ингээд хаагаад байна аа.

Тэгэхээр энэ цаашид энэ олон төслүүд яваад энэ нэг оффтейк гэж юмыг бүр ойлголтыг Монголчууд буруу төрүүлтэл нь ингэж энийг дахиж битгий хэрэглээч. Уул нь энд олон улсын худалдаанд энэ коммодити трейдингд оффтейк гэдэг чинь борлуулалтын урьдчилгаа мөнгө авах л харилцаа болохоос биш хөрөнгө оруулалтыг ингэж хийдэг, ялангуяа жишээлбэл хүн болгон гэрээ авъя гээд л ингээд л ярьж байгаа энэ үед ийм эрэлттэй байгаа үед нь өөрөөр хэлбэл энэ чинь мөнгө байхгүй юу. Тэгэхэд энийг зориуд ингэж хөрөнгө оруулалтад ашиглаж байгаа нэрээр өөр хүмүүст боломж олгоод хямдхан авах ийм үүд

хаалгыг нээгээд байна. Дахиж энэ хөрөнгө оруулалтын төслүүд тавьсан байна. Энэн дээрээ энэ оффтейк гэж энэ юу буруу байдлаар хэрэглэхээ болиоч ээ. Тэгэхгүй бол манай үнэ өсөхгүй байна аа. Өөрөөр хэлбэл бид нар нэмж нүүрс олборлохгүйгээр илүү мөнгө олох боломж байна. Энийгээ бид нар нэг гараараа зарж байгаа юм шиг нөгөө гараараа үнээ унагаад байна. Тэгээд ийм юм дахиж битгий хийгээч ээ. Тэгээд цаашидаа бүтэн зургаар нь эцсийн хэрэглэгч хүртэл юу байдаг гээд энэ бүтэн зургаа сайн ойлгооч. Өөрөөр хэлбэл Хятадын гангийн үйлдвэрүүд кокос химийн үйлдвэрүүд юу хүсдэг юм. Энэ чанарын шаардлага тавьж байна шүү дээ. 10.4 гээд нүүрс тавьж байна. Нүүрсний үндэслэлийг тавьж байна. Энэ чинь ийм олон ачиж буулгаад ирэхээр цаашаа очихоор жишээлбэл энэ үндэслэл нь жишээлбэл 11, 12 бараг болохоор байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь өөрөө буцаагаад жишээлбэл эцсийн хэрэглэгчийн шаардлага хангахгүй. Гэх мэтчилэнгээр олон зүйлүүд байгаа.

Тэгээд тэдэн километрийн радиуст ямар хэрэглэгч байгаа юм. Тэд нарын онцлог нь юу юм.

Хаана хаанаас авдаг юм. Манай өрсөлдөх чадвар юу юм? Цаашаа мянган км-т явахад тэдэн километр хэрэглэгч байдаг юм. Тийшээ очиход ямар тээвэр ложистикийн асуудлууд байдаг юм? Төлбөр мөнгөө Хятадын компаниуд яаж төлдөг юм тэр юмнуудаа сайн ойлгож ажиллаж чадвал бид нар илүү боломж байна энийгээ ашиглаач гэж хэлмээр байна.

Тэгэхийн тулд энэ өөрөө өөрсдийнхөө үнээ өсгөх боломжоо устгадаг энэ балай оффтейк гэдэг юмаа одоо боль оо. Дахиж ийм хөрөнгө оруулалтыг тэгж давхар ингэж хийдэг тэрийгээ зүгээр урьдчилж нэг гар талдаа мөнгөө авчхаад тэрүүгээрээ төслөө санхүүжээд ийм боломж байхад чинь 2 өөр хамааралгүй юмыг холбож

худалдааны компаниуд ийм боломж олгодгоо боль. Өөр нэг асуудал болохоор энэ Ерөнхий сайд, Сангийн сайд эд нар маш буруу ойлголттой байна лээ. Нүүрс удахгүй хог болно. Тэгээд бушуухан зарахгүй болохгүй гэдэг ийм ойлголт хүмүүс суулгаад байна лээ. Коксжих нүүрсний хувьд технологийн хувьд бол одоо энэ гангийн үйлдвэрүүдэд бол цахилгаан шийдэл байхгүй. Энэ шийдэл байлаа ч гэсэн ер нь бол энэ коксжих нүүрс хэрэглэж байж ганыг хайлуулдаг энэ технологи байсаар байгаа. Тэгэхээр энэнтэй холбогдсон ойлголтуудаа улс төрийн түвшиний шийдвэр гаргаж байгаа хүмүүстээ зөв ойлголт өгөхгүй бол эрчим хүчний нүүрсийг хольж ойлгоод коксжих нүүрсийг удахгүй хэрэггүй болно гэсэн байдлаар ийм буруу ойлголт нийгэмд мэдээлэл Ерөнхий сайдаас авхуулаад Сангийн сайд нь бүр итгэл үнэмшилтэйгээр байнга тэгж ярьж байна. Энийгээ та хэд засах талаар ойлголт өгөөрэй гэж хэлье.

С.Ганбаатар: Гишүүнд баярлалаа. Бадамсүрэн гишүүн үг хэлнэ.

М.Бадамсүрэн: Монгол Улсын Засгийн газраас энэ 3 шилжилт хийе. Шинэ сэргэлтийн бодлогоо үргэлжлүүлж гэсэн зорилт дэвшүүлсэн. Тэгээд энд нэгдүгээрт ухаалаг цахим шилжилтийг хийе гэж байгаа юм. Тэгэхээр энийг бүх үйл ажиллагаандаа манай энэ ялангуяа боловсруулах үйлдвэрүүд үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр зайлшгүй хийх ёстой.

Хоёрдугаарт нь ногоон шилжилт гэдэг бодлогыг Засгийн газар дэвшүүлж байгаа. Тэгээд энэ хүрээндээ энэ усны асуудал байгаль орчныг нөхөн сэргээх асуудал бүгд орж байгаа. Тийм учраас компанийн гүйцэтгэх удирдлагад зөвлөе гэж бодож байна. Та бүхэн ТУЗ, Засгийн газраар ирэх оныхоо төлөвлөгөө төсвийг батлуулахдаа байгаль орчныг нөхөн сэргээх чиглэлээр тэр орчны бохирдлыг бууруулах сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр болон ирээдүй үеэсээ энэ

зээлийг баялгийг зээлж хэрэглэж байгаа тэр говьд энэ одоо тухайн үед 2021 онд 500 хүрэхгүй мянган хүн байхдаа энэ чинь малчин түмэн чинь нүүдэллэж амьдардаг учраас говьд амьдарч байгаад тэгээд хөрсөн доороо энэ баялгаа бидэнд үлдээгээд өнөөдөр энүүгээр Монголын ард түмэн дийлэнх орлогоо олж байна шүү дээ.

Тийм учраас тэр нутгийн ард иргэдэд зориулсан хүүхэд хөгжүүлэхэд чиглэсэн ийм төсөл хөтөлбөрүүдийг та бүхэн хэрэгжүүлэх хэрэгтэй. Энэ бол нийгмийн хариуцлага. Энэ бол эцэг эхүүдийн өмнө хүлээсэн үүрэг.

Гуравдугаарт нь хүний нөөцийн шилжилт гэж байгаа. Тэгээд энэ хүрээндээ илүү чадварлаг инженер техникийн ажилтнуудыг ажиллуулах ялангуяа дотоодын боловсон хүчнийг итгэл үзүүлж маш сайн дэмжих хэрэгтэй. Заавал гадаадад төгссөн гэхээрээ төгс төгөлдөр хүн гэж байхгүй шүү дээ. Чин сэтгэлтэй эх орноо гэсэн бодолтой эх орноо хөгжүүлж эх орондоо хайртай ийм хүмүүсийг бэлдэхгүй бол болохгүй ээ. Энэ 3 зүйлийг зөвлөе гэж бодож байна. Тэгээд дараагийнх нь бол би Энхтүвшин гишүүнтэй санал нэг байна.

Нүүрс бараг хэрэггүй болно гээд үгүй ээ. Энэ эрчим хүчний хамгийн том дэлхийн эх үүсвэр. Энэ чинь олон 100 сая жилийн туршид энэ чинь ургамал энэ ой мод энэ зүйлээс үүссэн ийм эрдэс баялгийн хуримтлал шүү дээ. Үгүй ядаж гүн боловсруулалт хийнэ, устөрөгч гаргана, технологийн шинэчлэлүүд маш ойрхон хугацаанд хийгдэнэ. Тийм учраас энэ явж ирж байна гэж асуудал бидэнд байгаа. Ялангуяа энэ ТӨК-үд энэ байгалийн хэвлий доорх баялгийг ашиглаж байгаа энэ процесст зөв удирдах л ёстой. Баялгийг зөв удирдаж чадахгүй бол Африкийн, Латин Америкийн зарим орнуудын араас орно. Бүүр энэ нь одоо маш хэцүү байдалд биднийг оруулна.

Тийм учраас энэ баялгийг зөв удирдах асуудал чухал учраас та бүхэн төрийн өмчит энэ том компани бид нар бүгдээрээ хувьцаа эзэмшигч. Монголын ард түмэн хувьцаа эзэмшигч. 3 сая 500 мянган иргэн. Энэ утгаараа энэ ард иргэд чинь энэ Эрдэнэс Тавантолгой компанийн үйл ажиллагаанд маш сонор сэрэмжтэй хардаг шүү. Тэгээд зөвхөн Засгийн газрын л шийдвэрээр ингээд яваад байдаг зүйл биш шүү. Тийм учраас ямар үнэ цэнтэй том компанийг удирдаж Монголын ард түмэнд амьдрал ахуйг нь дээшлүүлэхэд, хүүхдүүдийг хөгжүүлэхэд, ахмадуудад дэмжлэг тусалцаа үзүүлэхэд ажиллаж байгаа гэдгээ их ийм ухамсарлаж ойлгож ажиллах хэрэгтэй л гэдгийг би чин сэтгэлээсээ хүсэж байна.

Энэ бол дотоодын хамгийн том компани. Төрийн өмчит компани. Тийм учраас дотоодын хамгийн том энэ Төрийн өмчит компани үлгэр жишээ Монголын ард түмэнд үр өгөөжөө өгдөг байх энэ зүйл дээр энэ компанийн удирдлага туйлын санаачилгатай ажиллах ёстой. Зүгээр бид нар ингээд Байнгын хороон дээр сонсоод өнгөрөх биш энд ярьж байгаа зүйлийг бүгдийг нь та бүхэнд очиж хурлаа хийж удирдлагын зөвлөлийн хурал дээрээ ярих хэрэгтэй. Тэгэхгүй блд Байнгын хороо нэг яриад өнгөрдөг асуугаад өнгөрдөг гэдэг байдлаар хандах юм блд харин дараа дараагийн удаа бид нар асуулга тавьж асуулт тавьж шаардлагатай бол энэ зүйл дээр яригдсан зүйлүүдээр эргэж би хандана гэж бодож байгаа. Миний хувьд бол нефтийн инженер мэргэжилтэй. Энэ талаар бас зах зухыг нь мэднэ. Энэ баялгийн.

С.Ганбаатар: Бадамсүрэн гишүүн үг хэллээ. Очирбат гишүүн үг хэлье.

Г.Очирбат: Эрдэнэс Тавантолгой компани бол Монголын бүх ард иргэдтэй хамааралтай хувьцаа эзэмшигч нар нь Монгол Улсын 4 зүг 8 зовхист байдаг. Тэгээд энэ том компанийг удирдаж авч явж байгаа та бүхэндээ бас дахин талархал илэрхийлье. Тэгээд би бас

түрүүн хэлсэн. Энэ мэргэжлийн Байнгын хороо. Аж үйлдвэржилтийн байнгын хороо. Энэ Байнгын хорооны дэмжлэг энэ Байнгын хорооны бодлогын бичиг баримт дээр ч тэр яг процессын ажил дээр ч тэр үйл ажиллагаа нь ч тэр ямар дэмжлэг байна гэдгийг та хэд маань илэрхийлээрэй. Энэ бол мэргэжлийн Байнгын хороо шүү. Олон тал асуудлыг олон талаас ярьж болно. Тэгэхдээ өнөөдөр бид нар яг потенциал нь эдийн засагт үр өгөөжөө өгч байгаа тэндээс улсын төсөвт хамгийн их нэмэр болж байгаа. Тэгээд Монгол Улсын энэ Эрдэнэс Тавантолгой компани ашигтай явж байж Монголын иргэн бүр хувьцааны ноогдол ашгаа өндөр авна л гэж ойлгох хэрэгтэй.

Тэгэхээр бид яг энэ Аж үйлдвэрийн бодлогын хорооны гишүүний хувьд би ч гэсэн бүх чадлаараа дэмжиж ажиллана. Шинэ техник, технологи, инновац яаж нэвтэрсэн юм та хэдтэй ямар санаа оноо явж байгаа юм. Цаашидаа менежмент чинь ямар явах юм ил тод байлгах тал дээр бүх тал дээр нь хууль эрх зүйн орчныг чинь дэмжиж ажиллана гэдгээ илэрхийлье, нэгдүгээрт.

Хоёрдугаарт гэх юм бол та хэд маань зөрүүлээд бас хариуцлагатай байх ёстой. Түрүүний энд сууж байгаа Их Хурлын гишүүдийн хэлж байгаа бол үнэн шүү дээ. Яг хариуцлагатай тэр оффтейк гэрээг, шууд гэрээг биржээр зарагдсан гэрээг бүр иргэддээ мэдээлдэг байх хэрэгтэй байхгүй юу. Тэгж байж нөгөө та хэдийг дээрээс чинь шахаж байгаа, дээрээс чинь эрх мэдлээр далайлгаж байгаа хүмүүсийн тэр айлгалт юу гэдэг юм тэр дарамт гэдэг юманд орохгүй л байна гэсэн үг шүү дээ. Нөгөө талдаа та хэд бол иргэдийн хамгаалалтад ингээд байгаа гэдгээ аягүй сайн сайн ойлгоорой. Тэгж ил тод явахгүйгээс болоод л энэ чинь асар их хэмжээний Эрдэнэс Тавантолгойтой холбоотой янз бүрийн мэдээлэл гардаг. Янз бүрийн гүжир гүтгэлэг гардаг.

Зарим тохиолдолд тэр чинь ихэнх дарга нар нь тэр түрүүн Байнгын хорооны дарга бас хэлж байна. Янз бүрийн байдлаар тэр шорон оронд ч юм уу орсон тохиолдол зөндөө л байна. Та хэд энэ дээрээ ч гэсэн хариуцлагатай байх ёстой. Ялангуяа залуучууд байна. Энэ Монгол Улс эх орны хамгийн том эдийн засаг хамгийн том хөрөнгө хөрөнгө дээр нь хамгийн том баялгийг нь та хэд удирдаж байгаа юм. Тэгэхээр ил тод нээлттэй байгаарай гэж захъя даа. Тэгээд өөр дэмжлэг байвал Их Хурлын гишүүнийхээ хувьд тултал нь дэмжиж явахаас өөр арга байхгүй. Бид нар энэ аж үйлдвэрийн салбараа хөгжүүлж байж Монголоос гарч байгаа нөөц болгоныг эцсийн бүтээгдэхүүн болгож гаднын зах зээл рүү экспортлож чадах л юм бол энэ Монгол Улсын эдийн засаг цаашаа хөгжлийн талаар ярина. Тэгээд би түрүүн жишээ татаад хэлсэн. Ажил дээр нь яг очиж үзэх хэрэгтэй.

Эрдэнэс Тавантолгой дээр явж очоод тэр конвертыг харчхаад би ингээд гайхаж байсан байхгүй юу. Конвертыг нь бариад дуусгачихсан. Хөрөнгө оруулалтаа хийгээд, ажил гүйцэтгэгч компани ажлаа хийгээд дуусгачихсан байж байхад Монголын төр мэргэжлийн байгууллагууд нь хүнд суртал үзүүлээд тэрийг нь хүлээж авдаггүй, очдоггүй, үздэггүй, ТӨК-удаа дэмждэггүй ийм юмнууд яг газар дээр байдаг л юм байна лээ. Тэгэхээр манай энэ мэргэжлийн Байнгын хорооныхон ажлын хэсэг гарвал Ганбаатар дарга ажлын хэсэгт нь орно. Хянах чиглэлээр, дэмжлэг үзүүлэх чиглэлээр, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр энэ тал дээр ажлын хэсэгт нь ороод ажиллахад бэлэн байгаа шүү гэдгээ илэрхийлье. Баярлалаа.

С.Ганбаатар: Очирбат гишүүнд баярлалаа. Золжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Золжаргал: Монголын нүүрсний аж үйлдвэрийн салбарт бас нэг ийм алхам болохуйц үйл явдал болж өнгөрөөд том хэмжээний баяжуулах үйлдвэрээ ашиглалтад оруулаад ажиллуулаад

эхэлчихсэн. Ямар ч байсан үүнд нь та бүхэндээ баяр хүргэе. Үйлдвэрийг барихад хөрөнгө оруулалт хэрэгтэй, мөнгө хэрэгтэй. Тэгээд мөнгө хэрэгтэй учраас оффтейк гэдэг механизмыг ашиглаад ингээд явдаг нь бол яах вэ олон улсад ер нь байдаг л зарчим. Тэгээд саяын энэ үйлдвэр бол тийм том хэмжээний нүүрсний борлуулалтын оффтейк гэрээтэй тэрүүгээрээ хөрөнгө оруулалтаа татаж байгаа. Яг энэ компанитай Дорнодын нөгөө газрын тосны дамжуулах хоолой бас нэг 2 их наяд төгрөгийн 500, 600 сая доллар байх аа. Гэрээтэй тийм оффтейк баталгаатай. Хуучин гэрээнүүд нь бол байгаа. Одоо ингээд хил холболтын төмөр замыг яаралтай эхлүүлэх хэрэгтэй. Энд бас нөхцөл нь болохоор худалдааны оффтейк том гэрээ байгуулна гээд. Ингээд том бүтээн байгуулалт хийж урагшаа явахын тулд тиймэрхүү гэрээ хэлэлцээр хийлгүй яах вэ. Гэхдээ хэмжээ, хугацаа, үнэ гэдэг ийм 3 юмыг бид нар маш сайн бодох хэрэгтэй байна.

Үнэ нь одоо жишээ нь энэ Норикотой хийсэн баяжуулах үйлдвэрийн оффтейкийн үнэ одоогийн үнэлгээгээр 74.5 доллар буюу 2025 оны Засгийн газраас гаргаж ирсэн энэ төсвийн юун дээр тооцоо хийсэн шүү дээ. 149.5. 149 доллар билүү. Яг 2 дахин бага үнэ байна гэсэн үг байхгүй юу. Тэгэхдээ энэ чинь түүхий нүүрсний үнэ баяжуулах нүүрсний үнэ бас ялгаатай. Тэгэхээр мэдээж бүх юмыг урьдчилж яаж харах вэ. Нөгөө талдаа бүр нүүрс нь унаад ингээд хэцүү болсон үед оффтейк мэдээж тус болж таарна. Гэхдээ энд хамгийн гол бодмоор юм хэмжээ байгаа юм. Нийт Монгол Улсаас гарч байгаа нүүрсний хэчнээн хувийг бид нар оффтейк байлгаж болох юм. Хэдэн сая 10, 20, 30 сая, 40, 50 ингээд явчих юм бол нөгөө том хэдэн гэрээнүүд нь найдвартай урт хугацаанд гээд явж байдаг. Гэтэл тэд нар нь ороод ирэхээр зах зээл чинь тодорхой хэмжээгээр ханаад жижиг хэмжээний тоглогч нар нь нөгөө бирж дээр нь орж ирэхээ болиод тэгээд үндсэндээ ингээд бирж

ажиллуулаад нэг жил гаруй ажиллуулаад л буцаад л саардаг. Монгол Улс нэг хууль гаргачхаад тэрийгээ хэрэгжүүлж чаддаггүй дундаасаа шантарчихдаг. Ийм байж болохгүй. Тэгэхээр Эрдэнэс Тавантолгой компанийнхан болоод Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, тэгээд Улсын Их Хурлын эрхэм гишүүд ч гэсэндээ та бүхэн энэ зүйл дээр анхаарал хандуулаасай гэж хүсэж байна. Тэгээд энэ бол цаад талдаа Монгол Улсын экспортын хамгийн том орлого зөвхөн нэг компанийн хувьд ч биш, нийт зах зээл, нийт нүүрсний үнэ, хөрөнгө оруулалтад нөлөөлнө. Тийм болохоор бид нар балансыг нь барихад бол онцгой анхаарал хандуулах хэрэгтэй байна гэж. Баярлалаа.

С.Ганбаатар: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Миний хувьд бол нэг зүйл бас хэлмээр байна. Гишүүд, ард иргэдийн төлөөлөл өнөөдрийн бидний гишүүдийн ярьж байгаа, хэлж байгаа, санал болгож байгаа зүйлүүд чин сэтгэлээсээ маш их цаг зав гаргаж ард иргэдийн нүд чих болж ажиллаж байгаа шүү. Тэгэхээр энэ ард түмний өмч, төрийн өмч биш шүү. Ард түмний өмчийг хариуцаж ажиллаж байгаа та нар саяын энэ гишүүдийн ярьж байгаа энэ санал бодол асуулга дээр ажил хэрэгч байдлаар хандана шүү. Нэг удаагийн хурлыг нэг эвтэйхэн аргалж өнгөрөөх гэдгээр биш өөрөөр хэлбэл энэ ярьж байгаа энэ олон зүйлүүд дээр бид араас нь шахаж шаардаж дэмжиж бас болохгүй зүйлийг нь засаж залруулж ажиллана. Та нар бичгээр энэ асуудлууд энэ үг хэлсэн саналууд ямар шатандаа явж байна. Юуг нь чадсангүй, юуг нь чадав гэдгээ байнга хариуцлагатайгаар хариулж явна шүү. Энэ бол ард түмний өмч хариуцаж байгаа улсууд та нар.

Үндсэндээ 3 дугаар улиралд гэхэд л 4.3 их наядын ашигтай ажилласан. Үнэхээр та нар сайн ажиллаж байна. Энэ бол олон олон сургууль, цэцэрлэг, эмнэлгийн ахмадын тэтгэврүүдийн цагдаа, цэрэг энэ олон санхүүжилт явж байгаа юм. Цаана нь 5.3 их наядын зардал гаргасан. Энэ дээр шатах тослох материалд хэдийг зарцуулсан юм. Та нар цалин хөлсөнд хэдийг өгсөн юм. Худалдан авах ажиллагаанд хэдийг өгсөн юм. Зар сурталчилгаа рекламдаа хэдийг өгсөн юм гэдэг энэ асуудал дээр бид ард иргэдийг төлөөлж хяналт тавина аа. Энэ дээрээ бас дэлгэрэнгүй мэдээлэл авна. Өнөөдөр тэр тухай ерөөсөө ярьсангүй.

Тэгэхээр гол хэлэх гээд байгаа зүйл маань гишүүдийн одоо манай Байнгын хороо бол өөр ажиллана. Үр дүнтэй ажиллана. Тэгэхээр та нарын энэ ярьж байгаа зүйлүүд зүгээр ажил хэрэгч болгоно оо. Ингээд та бүхний мэдээлэл хийж гишүүд асуулт идэвхтэй хариулт авч санал бодлоо илэрхийллээ. Өнөөдрийн түрүүн би хэлсэн бас дахиад албан ёсоор хэлье. Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан хяналт шалгалтын ажлын цаглаварт Байнгын хорооноос санал оруулж Байнгын хорооны гишүүдийг оролцуулж Эрдэнэс Тавантолгой компанийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцах асуудлаар Их Хурлын даргын энэ захирамжид багтаж бид ажиллана аа.

Ингээд та бүхний мэдээллийг сонслоо. Өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье.

12.30 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА